



Ардчилсан Институт, Хүний Эрхийн Газар

## МОНГОЛ УЛС

ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛЬ  
2021 оны 6 дугаар сарын 9 өдөр

АИХЭГ-ЫН Сонгууль ажиглах тусгай хорооны  
Эцсийн тайлан



Варшав хот  
2021 оны 10 дугаар сарын 22

## ГАРЧИГ

I.	ХУРААНГУЙ.....	1
II.	ТАНИЛЦУУЛГА, ТАЛАРХАЛ .....	4
III.	ОРШИЛ БА УЛС ТӨРИЙН ОРЧИН .....	4
IV.	ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН БА СОНГУУЛИЙН ТОГТОЛЦОО .....	5
V.	СОНГУУЛИЙН БАЙГУУЛЛАГА.....	7
VI.	САНАЛ ТООЛОХ ТӨХӨӨРӨМЖ .....	9
VII.	СОНГОГЧИЙН БҮРТГЭЛ .....	10
VIII.	НЭР ДЭВШИГЧИЙН БҮРТГЭЛ .....	12
IX.	СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГАА .....	13
X.	СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГААНЫ САНХҮҮЖИЛТ .....	16
XI.	ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ.....	17
A.	Хэвлэл мэдээллийн орчин .....	17
B.	Хэвлэл мэдээллийн хууль эрх зүйн орчин .....	18
C.	Сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх эрх зүйн зохицуулалт .....	19
D.	Сонгуулийн сурталчилгааны хэвлэл мэдээлэл.....	21
XII.	ИРГЭНИЙ БОЛОН ОЛОН УЛСЫН АЖИГЛАГЧ.....	22
XIII.	СОНГУУЛИЙН ӨДӨР.....	23
XIV.	СОНГУУЛИЙН ДҮНГ НЭГТГЭЖ, ЗАРЛАХ ҮЙЛ ЯВЦ.....	23
XV.	ӨРГӨДӨЛ ГОМДОЛ .....	24
XVI.	ЗӨВЛӨМЖ .....	26
A.	Нэн тэргүүний зөвлөмжүүд.....	26
B.	Бусад зөвлөмжүүд .....	27
	ХАВСРАЛТ – СОНГУУЛИЙН ДҮН .....	30
	АИХЭГ-ЫН ТУХАЙ .....	31

**МОНГОЛ УЛС  
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛЬ  
2021 оны 6 дугаар сарын 9 өдөр**

**АИХЭГ-аас томилогдсон Сонгууль ажиглах тусгай хорооны эцсийн тайлан<sup>1</sup>**

**I. ХУРААНГУЙ**

Монгол Улсын эрх бүхий байгууллагаас ирүүлсэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийг ажиглах урилгын дагуу Европын Аюулгүй Байдал, Хамтын Ажиллагааны Байгууллага (ЕБХАБ)-ын Ардчилсан институт, хүний эрхийн газар (АИХЭГ) нь өөрийн чиг үүргийн дагуу 2021 оны 6 дугаар сарын 9-ний өдөр явагдсан Ерөнхийлөгчийн сонгуулийг ажиглахаар 2021 оны 5 дугаар сарын 21-ний өдөр Сонгууль ажиглах тусгай хороо (CATX) байгуулан ажилалаа. АИХЭГ-ын CATX нь сонгуулийн үйл явц ЕАБХАБ-ын өмнө хүлээсэн үүрэг, ардчилсан сонгууль, дотоод хууль тогтоомжтой хэрхэн нийцэж буйд үнэлгээ хийсэн. АИХЭГ-ын CATX нь сонгуулийн өдрийн үйл ажиллагааг АИХЭГ-ын аргачлалын дагуу иж бүрэн, системтэйгээр ажиглаагүй хэдий ч цөөн тооны санал авах байранд очиж ажиглалт хийсэн болно.

АИХЭГ-ын CATX нь 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн Урьдчилсан үр дүн, дүгнэлтийн тайландаа 2021 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн Ерөнхийлөгчийн сонгууль нь үр дүнтэй зохион байгуулагдаж, нэр дэвшигчид сонгуулийн сурталчилгаагаа чөлеөтэй явуулж чадсанч нэр дэвших эрх ихээхэн хязгаарлагдмал, хэвлэл мэдээллийн харилцааг хэт зохицуулж байсан нь сонгогчдын мэдээлэлд суурилж сонголт хийх бололцоонд сөргөөр нөлөөлж байсныг дурдсан.

Энэ удаагийн ерөнхийлөгчийн сонгууль нь 2020 оны Улсын Их Хурал (УИХ)-ын болон орон нутгийн хоёр сонгуулийн дараа, эрх баригч Монгол Ардын Нам (МАН) парламентийн олонх байдлаа хэвээр хадгалж, дийлэнх аймаг, орон нутгийн засаг захиргаанд эрх мэдлээ хэрэгжүүлж байх үед зохион байгуулагдсан. Үндсэн хуулийн цэцийн 2021 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн шийдвэрийн дагуу сөрөг хүчин Ардчилсан нам (АН)-аас 2017 онд сонгогдсон ерөнхийлөгч Халтмаагийн Battulgyn нь бүрэн эрхийн хугацаанд өөрчлөлт орсон тул дахин нэр дэвших боломжгүй болсон. Мөн энэ сонгууль нь Коронавируст халдварт /КОВИД-19/-ын цар тахлын тохиолдол улс орон даяар, ялангуяа Улаанбаатар хотод ихсэж буй үед зохион байгуулагдсан нь сонгуулийн байгууллага болон нэр дэвшигчдийн сонгуулийн сурталчилгааны ажилд сорилт болсон.

Ерөнхийлөгчийн сонгуулийг шинэчилсэн хууль, эрх зүйн орчинд зохион байгуулсан. Үүнд 2019 оны Үндсэн хуульд оруулсан нэмэлт өөрчлөлт багтах бөгөөд энэхүү нэмэлт, өөрчлөлтөөр Ерөнхийлөгчийн эрх мэдлийг хязгаарлаж, зургаан жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа сонгохоор хуульчилсан байна. 2020 онд батласан Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай (ECTX) шинэ хууль, тогтоомж нь ерөнхийдөө ардчилсан сонгууль зохион байгуулахад хангалттай, иж бүрэн зохицуулалттай болсон хэдий ч өмнөх АИХЭГ-аас гаргасан хэд хэдэн зөвлөмжийг тусгаагүй байна. Ялангуяа Улсын Их Хуралд суудалгүй улс төрийн нам болон бие даагч нар нэр дэвших эрхтэй байх, оюуны болон сэтгэцийн асуудалтай, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сонгуульд оролцох эрх зүйн орчин хязгаарлагдмал, сонгуультай холбоотой гомдол, маргаан хянан шийдвэрлэх хугацаа нь сонгуулийн хуанлитай нийцдэггүй, сонгуулийн сурталчилгааны ажил болон хэвлэл мэдээллийн эрх зүйн орчин хязгаарлагдмал, мөн сонгуулийн сурталчилгааны санхүүжилтийн хяналт хангалтгүй байгаатай холбоотой бусад зөвлөмжүүдийг орхигдуулсан хэвээр байна.

<sup>1</sup> Энэ тайлангийн Англи хувилбар нь албан ёсны баримт бичиг мөн. Монгол хувилбар нь албан бусаар орчуулагдсан болно.

Сонгуулийн байгууллага нь сонгуулийн бэлтгэлд хамаарах техникийн ажлуудыг үр дүнтэй, мэргэжлийн өндөр түвшинд зохион байгуулж, хуулийн хугацааг мөрдөж ажиллалаа. Бүх шатны сонгуулийн хороод оролцогч талуудын итгэлийг хүлээж чадсан. Талууд бүх шатны сонгуулийн хороодод итгэлтэй байсан. Сонгуулийн ерөнхий хороо (СЕХ) ганцхан эмэгтэй гишүүнтэй байсан ч доод шатны бүх сонгуулийн хороодод эмэгтэйчүүдийн төлөөлөл хангалттай сайн байж чадсан. Ихэнх шийдвэр, журмууд СЕХ-ны цахим хуудаснаа цаг тухайд нь нийтлэгдэж байсан ч хуралдаан, хуралдааны хэлэлцэх асуудлын товыг урьдчилж нийтлээгүй нь тэдний ил тод байдлыг бууруулсан үзүүлэлт болсон. Засгийн газраас СЕХ болон Улсын онцгой комисстий хамтран сонгуулийн үеэр Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх түр журмыг баталсан ба уг журмаар цар тахалд өртсөн сонгогчдыг саналаа өгөх боломжоор ханган зохицуулжээ. Хэд хэдэн ИНБ-ын саналаар СЕХ сонсгалын болон харааны бэрхшээлтэй иргэдэд сонгуулийн мэдээллийн хүртээмжийг сайжруулахаар хүчин чармайлт гарган ажилласан.

Бүх санал авах байр санал тоолох төхөөрөмжтэй ч энэ удаагийн сонгуулиар нэмэлтээр хяналтын тооллогыг бүх санал авах байранд хийхээр хуульчилсан байна. Талууд санал тооллогын шударга, үнэн зөв байдалд итгэж буйгаа илэрхийлсэн. СЕХ-ны зүгээс улс төрийн намууд болон иргэний нийгмийн төлөөллийг урьж санал тоолох төхөөрөмжийн эх код болон ажиллагааг турших сонгуулийн өмнөх туршилтад оролцуулан ил тод байдлаа сайжруулсан байна. Бүх төхөөрөмжүүд төрийн байгууллагаар хянагдаж, баталгаажсан байсан ч АИХЭГ-ын зөвлөмжийн дагуу бие даасан, хөндлөнгийн хяналт, баталгаажилт хийх талаар хуулийн шаардлага дутмаг хэвээр байна.

Үндсэн хуулиар 18 нас хүрсэн иргэд санал өгөх эрхтэй. Сонгогчдын нэрийн жагсаалтыг Улсын бүртгэлийн ерөнхий газар (УБЕГ)-ын иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд үндэслэн гаргасан ба бүх санал авах байранд сонгогчдын бүртгэлийг хурууны хээ уншиж баталгаажуулах төхөөрөмж ажиллуулдаг. АИХЭГ-ын САТХ-той уулзаж, ярилцсан хүмүүс сонгогчдын нэрийн жагсаалтын үнэн зөв байдал болон бүх сонгогчдыг ялгаварлахгүйгээр оролцуулсан эсэхэд эргэлзэхгүй байсан хэдий ч иргэний ажиглагчдад сонгогчдын нэрийн жагсаалтыг бүхлээр нь танилцуулахгүй байсан нь системчилсэн үнэлгээ болон судалгаа гаргахад хангалтгүй байсныг дурдсан. ЕСТХ-нд шүүхээр эрх зүйн чадамжгүй нь тогтоогдсон, оюуны болон сэтгэцийн бэрхшээлтэй, гэмт хэрэг үйлдэн хорих ял эдэлж буй хүмүүсийн санал өгөх эрхийг хязгаарласан хэвээр байна.

СЕХ гурван нэр дэвшигч бүртгэнээс бүгд эрэгтэй байна. Монгол Улсын засгийн газарт өгч байсан АИХЭГ-ын өмнөх зөвлөмжийн дагуу цэргийн алба хааж байгаагүй, урьд өмнө ял шийтгүүлж байсан зэрэг нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзах үндэслэл бүхий заалт, шаардлагуудыг хуулиас хассан байна. Гэсэн хэдий ч оршин суугаа газар, гарал үүсэлд үндэслэн нэр дэвших эрхийг хязгаарласан заалтыг үлдээн, оюуны болон сэтгэцийн эмгэгтэй хүний нэр дэвших эрх, авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн нь шүүхийн шийтгэх тогтоолоор тогтоогдсон ч ял эдлээгүй хүн нэр дэвшихийг хориглосон нь олон улсын стандарт, зүй ёсны үйл ажиллагаатай нийцэхгүй байна. Зөвхөн Улсын Их Хуралд суудалтай намууд нэр дэвшигчийг тодруулах эрхтэй байгаа нь ЕАБХАБ-ын өмнө хүлээсэн үүрэг амлалттай нийцэхгүй байгаа юм. Өмнө нь АИХЭГ-аас гаргасан зөвлөмжийг үл харгалзан, нэр дэвшигчийг бүртгэх хугацаа богино, сонгуулийн үйл ажиллагааны хуанлийн хувьд харьцангуй хожуу эхэлж байгаа нь нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзсан тохиолдолд шүүхээр үр дүнтэй шийдвэрлүүлэх эрхэд халдаж болзошгүй байна.

АИХЭГ-ын САТХ-ны ажигласан үйл ажиллагаануудад эрүүл мэндийн холбогдолтой, цар тахлын эсрэг олон нийтийн уулзалт, арга хэмжээ зохион байгуулахад тодорхой хэмжээний хязгаарлалтууд байсан ч нэр дэвшигчид ямар нэг хөндлөнгийн оролцоогүйгээр сурталчилгаагаа чөлөөтэй явуулах боломжтой байв. ЕСТХ нь нэр дэвшигчид сонгуулийн сурталчилгааны ажлаа

хэрхэн зохион байгуулах, штабын ажилчид, хөрөнгө, материал, нийгмийн сүлжээ буюу сошиал медиа хэрэглээ, зөвшөөрөгдсөн үйл ажиллагааг жагсаасан зэргээр ихэд зааварласан шинжтэй байна. Сонгуулийн сурталчилгааны ажлыг сонгуульт болон улс төрийн томилгоогоор томилогдсон төрийн албан хаагчид дэмжсэн хэд хэдэн тохиолдол бүртгэгдсэн ба энэ нь хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн байдаг. Сонгууль болохоос хэдхэн сарын өмнө Засгийн газар нийгмийн хэд хэдэн бүлгүүдэд татаас болон бусад тэтгэмж олгох хөтөлбөрүүд хэрэгжүүлсэн нь эрх баригч намын нэр хүндийг өсгөж өгсөн. Сурталчилгааны болон сонгуультай холбоотой мэдээлэл үндэсний цөөнхийн хэл дээр цөөн тоогоор хэвлэгдсэн байна.

Сонгуулийн сурталчилгааны санхүүжилтийн ерөнхий тогтолцооны хяналт, ил тод байдлыг хангалттай зохицуулаагүй нь сонгогчид нэр дэвшигчдийн орлогын эх үүсвэрийн талаарх мэдээлэл авах бололцоог хязгаарлаж байсан. Үндэсний аудитын газар (УАГ) нь сонгуулийн санхүүжилтэд хяналт тавих чиг үүрэгтэй ч сонгуулийн сурталчилгааны үеэр газар дээр нь хяналт тавьж, мэдээлэл цуглувладаггүй тул тайланд тусгагдсан хандив, сонгуулийн зардлыг бүрэн баталгаажуулах боломжгүй юм. Сонгуулийн сурталчилгааны санхүүжилтийн тайланг хүргүүлэх үйл ажиллагаа тодорхой хэмжээгээр сайжирсан ч УАГ эдгээр тайланг олон нийтэд танилцуулдаггүйгээс гадна өөрийн хяналтын дүгнэлтийг бүрэн болон хураангуйлан нийтэлдэггүй байна.

Хэвлэл мэдээллийн орчин маш идэвхтэй боловч хязгаарлагдмал зар сурталчилгааны зах зээлд 500 орчим хэвлэл мэдээллийн байгууллага үйл ажиллагаа явуулж байгаагаас ихэнх нь санхүүгийн хувьд бие даасан бус, улс төрийн нөлөөнд байдаг. Үндсэн хуулиар үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хангахын зэрэгцээ бусад хууль тогтоомжоор хэвлэл мэдээллийн зохистой эрх зүйн орчинг бүрдүүлсэн. Гэсэн хэдий ч АИХЭГ-ЫН САТХ-той уулзсан зарим хүмүүс гүтгэлэг, худал мэдээлэлтэй холбоотой хариуцлага хүлээлгэх заалт хуулинд нэмэгдсэн нь сэтгүүлчид өөрсдөө цензур тавихад хүргэдэг талаар мэдээлж байсан. Түүнчлэн сонгуулийн сурталчилгааны үеийн нэвтрүүлэг, цахим орчин дахь мэдээллийн хэт хязгаарлагдмал зохицуулалт нь редакцын эрх чөлөөг хязгаарлаж, хараат бус мэдээллийг дамжуулах хэвлэл мэдээллийн үүргийг бууруулж, нэр дэвшигч, тэдний мөрийн хөтөлбөрийн талаарх бие даасан мэдээллийг авах сонгогчдын боломжийг хааж байв.

Сонгуулийн өдөр ямар нэгэн ноцтой асуудалгүй зохион байгуулагдсан ба АИХЭГ-ЫН САТХ-ны айлчилсан цөөн тооны санал авах байрууд дэг журмаа сахиж байсан. Хяналтын тооллого хийх, тооллогын үр дүнг нэгтгэх үйл явцыг тодорхой, нарийвчлан зааж өгөөгүй хэдий ч үүнтэй холбоотой нэг ч албан ёсны гомдол ирээгүй байна. СЕХ сонгуулийн дүнг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацаа болон Улсын Их Хурал Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрөх тухай хууль батлах хугацаа хэт богино байсан нь сонгуулийн дүнгийн эсрэг гомдол гаргах боломжид сөргөөр нөлөөлж болзошгүй. Мөн сонгуулийн дүнг хэсгийн хороо тус бүрээр нь задаргаа хийн олон нийтэд мэдээлээгүй нь нийт сонгуулийн үйл явцын ил тод байдалд сөргөөр нөлөөлсөн. Сонгуулийн өдөр иргэний ажиглагчид ажилласан нь сонгуулийн үйл явцад эерэг нөлөөтэй байсан ч иргэний ажиглагчдийг бүртгэн, итгэмжлэл олгох үйл явц нь тэднийг санал өгөх байруудад томилоход хүндрэл учруулж байсан. Цаашид иргэний ажиглагчид сонгуулийн бүхий л үе шатыг ажиглах бололцоог сайжруулах ёстой.

Сонгуулийн гомдол, маргааныг хянан шийдвэрлэх тогтолцоонд сонгуультай холбоотой хэрэг, зөрчлийг шалган шийдвэрлэх хэд хэдэн хууль байдаг ч, хянан шийдвэрлэх үйл явц нь сонгуулийн хуанлитай зөрчилдсөн, сунжирдаг байдал нь нь шүүхээр үнэн зөв шийдвэрлүүлэх эрхэд саад болох магадлалтай байна.

Энэхүү тайлан нь Монгол Улсын сонгуулийн хууль тогтоомжуудыг ЕАБХАБ-ЫН өмнө хүлээсэн үүрэг, ардчилсан сонгуультай холбогдох олон улсын бусад хэм хэмжээнд нийцүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилго бүхий зөвлөмжүүдийг агуулсан болно. АИХЭГ-ЫН САТХ-ны нэн тэргүүний

Зөвлөмжүүдэд нэр дэвших эрхийн хэт хязгаарлагдмал байдлыг болиулах, сонгуулийн сурталчилгаа болон хэвлэл мэдээллийн тодорхой дүрэм, журмуудыгэргэн харах, сонгуулийн хороодын чиг үүрэг, сонгогчдын нэрийн жагсаалт, сонгуулийн сурталчилгааны санхүүжилт, сонгуулийн ажиглалттай холбоотой зохицуулалт, ажиллагааны ил тод байдал, хариуцлагын механизмыг сайжруулах талаар багтсан болно. АИХЭГ нь сонгуулийн үйл явцыг сайжруулахад энэхүү тайлан болон өмнөх тайлангуудад өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэхэд нь холбогдох эрх баригчдад дэмжлэг үзүүлэхэд бэлэн гэдгээ үүгээр илэрхийлж байна.

## II. ТАНИЛЦУУЛГА, ТАЛАРХАЛ

Монгол Улсын Гадаад харилцааны яамны урилга, 2021 оны 3 дугаар сарын 22-оос 26-ны өдрүүдэд хийгдсэн Урьдчилсан үнэлгээний судлагааны (ҮҮС)-ын тайландаа тусгагдсан зөвлөмжид үндэслэн ЕАБХАБ-ын Ардчилсан институт, хүний эрхийн газар (АИХЭГ) нь 2021 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийг ажиглахаар Сонгууль ажиглах тусгай хороо (CATХ)-г мөн оны 5-р сарын 21-ний өдөр байгуулав. CATХ-г Лолита Сиганегаар удирдуулсан ЕАБХАБ-ын гишүүн, долоон улсын төлөөлөл болсон 10 хүний бүрэлдэхүүнтэй шинжээчид ажилласан болно.<sup>2</sup> CATХ-ны бүрэлдэхүүн 2021 оны 6 дугаар сарын 19-ний өдөр хүртэл Монгол Улсад ажилласан.

АИХЭГ-ын CATХ нь сонгуулийн үйл явц ЕАБХАБ-ын өмнө хүлээсэн үүрэг амлалт, ардчилсан сонгуультай холбоотой олон улсын бусад хэм хэмжээ, түүнчлэн дотоодын хууль тогтоомжууд хэрхэн мөрдөгдөж, нийцэж байгаа талаар үнэлгээ хийсэн болно. АИХЭГ-ын CATХ нь сонгуулийн өдрийн санал авах, санал тоолох, үр дүнг нэгтгэх үйл явцыг АИХЭГ-ын аргачлалын дагуу иж бүрэн, системтэйгээр ажиглаагүй хэдий ч тус хорооны гишүүд цөөн тооны санал авах байранд очиж ажиглалт хийсэн болно. Уг эцсийн тайланг 2021 оны 6-р сарын 10-ны өдөр нийтэлсэн Урьдчилсан үр дүн, дүгнэлтийн тайландаа үндэслэн боловсруулсан.

АИХЭГ-ын CATХ нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийг ажиглах урилга ирүүлсэн Монгол Улсын эрх бүхий байгууллага, ялангуяа Сонгуулийн ерөнхий хороо (СЕХ), Гадаад харилцааны яам (ГХЯ)-д дэмжиж туслан хамтран ажилласанд талархлаа илэрхийлж байна. Мөн өөрсдийн үзэл бодлоо хуваалцсан бусад төрийн байгууллага, шүүх, улс төрийн нам, хэвлэл мэдээллийн байгууллага, иргэний нийгмийн байгууллага, олон улсын байгууллагуудын төлөөлөл болон бусад уулзсан хүмүүст хамтран ажилласанд мөн талархаж буйгаа илэрхийлж байна.

## III. ОРШИЛ БА УЛС ТӨРИЙН ОРЧИН

Монгол Улс нь холимог буюу хагас ерөнхийлөгчийн засаглалтай, гадаад бодлого, батлан хамгаалахын асуудлыг Ерөнхийлөгч, харин гүйцэтгэх эрх мэдлийг Ерөнхий сайдаар ахлуулсан Засгийн газархэрэгжүүлдэг бүгд найрамдах улс юм. Хууль тогтоох эрх мэдлийг нэг танхимтай Улсын Их Хурал (парламент) хэрэгжүүлдэг байна.

Улсын Их Хурал 2021 оны 1 дүгээр сарын 20-ний өдөр Монгол Улсын найм дахь ерөнхийлөгчийн сонгуулийг 2021 оны 6 дугаар сарын 9-ний өдөр хийхээр товлон зарласан. Энэ удаагийн сонгууль нь Ерөнхийлөгчийн эрх мэдлийг УИХ-д ашигтай байхаар бууруулж, ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацааг зургаан жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа байхаар болгон өөрчилсөн 2019 оны Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаас хойшхи анхны

<sup>2</sup> CATХ-ны үндсэн баг дөрвөн эмэгтэй, зургаан эрэгтэйгээс бүрдэв.

ерөнхийлөгчийн сонгууль юм. Ерөнхийлөгчийн сонгууль нь 2020 оны Улсын Их Хурлын болон орон нутгийн сонгуулийн дараа явагдсан ба 2020 оны сонгуулиудын үр дүнд Монгол ардын нам (МАН) парламентийн олонх байдлаа хэвээр хадгалж, дийлэнх аймаг, орон нутгийн засаг захирагаанд эрх мэдлээ хэрэгжүүлж байх үед зохион байгуулагдсан байна.<sup>3</sup>

Ухнаагийн Хүрэлсүх албан тушаалаасаа огцорч одоогийн Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ 2021 оны нэгдүгээр сарын 27-нд ерөнхий сайдын үүрэгт ажлыг хүлээн авсан нь Хүрэлсүхийн ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшихийн тулд хийсэн үйлдэл гэж иргэд тайлбарлаж байсан. 2011 онд хуваагдсан МАН, Монгол ардын хувьсгалт нам (МАХН) дахин нэгдсэнээр МАН У.Хүрэлсүхийг нэр дэвшигчээр тодруулав.

Ерөнхийлөгчийг зөвхөн нэг удаа сонгох заалтыг энэ удаагийн сонгуулиас мөрдөж эхлэх тухай Үндсэн хуулийн цэц (ҮХЦ)-ийн 2021 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн шийдвэрийн дагуу 2017 онд АН-аас сонгогдсон Ерөнхийлөгч Халтмаагийн Баттулга нь дахин нэр дэвших эрхгүй болсон (*Хууль эрх зүйн орчин хэсгийг харна уу*). Ардчилсан нам (АН) нь 2020 оны УИХ-ын сонгуулийн араас намын удирдлагын асуудлаар дотооддоо зөрчилтэй байсаар энэ сонгуулийг угтсан байна. Энэ дотоод хагарлаар АН хоёр хуваагдаж, нэг талыг нь Содномзундуйн Эрдэнэ тэргүүлэх болсон. Хоёр тал аль аль нь АН-ыг төлөөлөх хууль ёсны эрхтэй хэмээн СЕХ-нд нэр дэвшигчээ бүртгүүлэх хүсэлтээ хүргүүлсэн ч 2017 онд намын сунгаагаар С.Эрдэнийг намын даргаар бүртгэсэн Дээд шүүхийн тогтоолд үндэслэн СЕХ С.Эрдэнийг АН-н нэр дэвшигчээр бүртгэсэн юм. Үүний хариуд Улсын Их Хурал дахь ихэнх АН-ын гишүүд нөгөө талыг дэмжин, СЕХ-ны С.Эрдэнийг нэр дэвшигчээр бүртгэсэн шийдвэрийг эсэргүүцэн, СЕХ намын дотоод асуудалд хөндлөнгөөс оролцлоо хэмээн төрийн ордны урд өлсгөлөн зарлажээ (*Нэр дэвшигчийн бүртгэл хэсгийг харна уу*). Зөв хүн электорат эвсэл (ЗХЭЭ) 2020 онд УИХ-д суудалтай болсноор Ерөнхийлөгчийн сонгуульд анх удаа оролцож буй бөгөөд Улсын Их Хурлын гишүүн асан Дангаасүрэнгийн Энхбатыг нэр дэвшигчээр тодруулсан.

Энэ удаагийн сонгууль Коронавируст халдварт /КОВИД-19/-ын цар тахлын тохиолдол улс орон даяар, ялангуяа Улаанбаатар хотод ихсэж буй үед зохион байгуулагдсан нь сонгууль зохион байгуулах байгууллага болон нэр дэвшигчдийн сурталчилгааны ажилд сорилт болсон.

Улс төр дэх эмэгтэйчүүдийн оролцоо бага хэвээр байна. Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулиар нэр дэвшиж буй нийт нэр дэвшигчдийн 20-оос доошгүй хувь нь аль нэг хүйсийнх байх, Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулиар бүртгэлтэй улс төрийн намуудын төв болон орон нутгийн байгууллагын нийт гишүүдийн 25-аас доошгүй хувь нь эмэгтэйчүүд байна гэж тус тус заасан байдаг. Гэсэн хэдий ч Улсын Их Хурал болон бусад шийдвэр гаргах түвшний албан тушаалд эмэгтэйчүүд цөөхөн хэвээр байна.<sup>4</sup> Энэ удаагийн ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдсөн турван нэр дэвшигч бүгд эрэгтэй байлаа.

#### **IV. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН БА СОНГУУЛИЙН ТОГТОЛЦОО**

Монгол Улсын сонгуулийн хууль, эрх зүйн орчин ерөнхийдөө ардчилсан сонгууль зохион байгуулахад хангалттай, иж бүрэн зохицуулалттай. Сонгуулийн хууль эрх зүйн орчин нь 1992

<sup>3</sup> УИХд МАН 62, Ардчилсан нам (АН) 11, Хөдөлмөрийн үндэсний нам, Зүй ёс нам, Монголын социал демократ намаас бүрдсэн Зөв хүн электорат эвсэл (ЗХЭЭ) 1, Монгол ардын хувьсгалт нам (МАХН), Иргэний зориг ногоон нам, Монголын уламжлалын нэгдсэн намаас бүрдсэн Та бидний эвсэл 1 суудал авсан байна. Та бидний эсвлээс сонгогдон Улсын Их Хурлын гишүүн МАН-д нэгдэн орсны дараахан УИХ дахь АН-ын бүлэгт элсэн орсон бол мөн адил, бие даагч УИХ-ын гишүүн АН-д элсэн оржээ.

<sup>4</sup> Нийт 76 Улсын Их Хурлын гишүүний 13 (17 хувь) эмэгтэй бөгөөд Засгийн газрын 17 гишүүдийн 4 нь эмэгтэй байна. 21 аймгийн Засаг дарга нарын аль нь ч эмэгтэй биш.

оны Үндсэн хууль (сүүлд 2019 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан), 2020 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай, 2006 оны Сонгуулийн төв байгууллагын тухай, 2005 оны Улс төрийн намын тухай зэрэг хуулиудаас түлхүү бүрдсэн байна.<sup>5</sup> Ардчилсан сонгууль явуулахтай холбоотой олон улсын гэрээ, конвенцид Монгол Улс нэгдэн орсон байдаг.<sup>6</sup>

Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг 2019 оны 11 дүгээр сард батлахдаа Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг зургаан жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа сонгоно гэж бууруулсан, насны шалгуур 45 нас байсныг 50 болгож нэмсэн, улс төрийн нам шинээр бүртгүүлэхэд шаардлагатай гишүүнчлэлийн тоог нийт сонгогчдын 1 хувь байхаар заасан ба сонгуулийн хууль, тогтоомжид ээлжит сонгуулиас нэг жилийн өмнө нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглосон заалтуудыг хуульчилсан байна.<sup>7</sup>

Улсын Их Хурал 2018 онд сонгуулийн цаг хугацаа, үйл явцыг өөр өөр сонгуульд тохируулан хэрэгжүүлэх зорилгоор 2015 оны Сонгуулийн тухай хуулийг салгасан байна. Үүний үр дүнд 2020 оны 12 дугаар сард Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай шинэ хуулийг баталсан.<sup>8</sup> АИХЭГ-ын САТХ-ны уулзсан төлөөлөгчид уг хуулийн болон Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хэлэлцүүлгийг оролцооны аргад тулгуурлан зохион байгуулсан ч цаашид дахин хянан авч үзэж, сайжруулах шаардлагатай болохыг тэмдэглэсэн. Шинэчлэн баталсан уг хуульд сонгогчдын нэрийн жагсаалтад байгаа мэдээллийг иргэд баталгаажуулах боломжийг нэмэгдүүлэх, ял шийтгүүлж байсан эсвэл цэргийн алба хаасан эсэхтэй холбоотой нэр дэвшигчдэд тавьж буй тодорхой хязгаарлалтуудыг хүчингүй болгох зэрэг АИХЭГ-ын зарим зөвлөмжүүдийг тусгасан байна. Харин Улсын Их Хуралд суудалгүй улс төрийн нам нэр дэвшүүлэх эрхтэй байх, бие даан нэрээ дэвшүүлэх эрхтэй байх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сонгуульд оролцох эрх зүйн орчин хязгаарлагдмал, өргөдөл, гомдол хянан шийдвэрлэх хугацаа сунжирдаг байдал, сонгуулийн нэг болон хоёр дахь шатны санал хураалтын хооронд сонгуулийн сурталчилгаа явуулахыг хориглосон зохицуулалт, сонгуулийн сурталчилгааны санхүүжилтийн хяналт хангалтгүй байгаатай холбоотой бусад зөвлөмжүүдийг орхигдуулсан хэвээр байна.

*Улсын Их Хурал сонгуулийн хууль, тогтоомжийг оролцогч бүх талуудтай хамтран дараагийн сонгууль болохоос нилээдгүй хугацааны өмнөөс өргөн хүрээнд, оролцооны аргад тулгуурлан хэлэлцээж, шинэчлэх ёстой бөгөөд үүнд АИХЭГ-ын энэхүү тайлан болон өмнөх тайлангуудад өгсөн зөвлөмжүүдийг тусган хэрэгжүүлэх.*

Ерөнхийлөгч нь улсын хэмжээнд сонгуулийн нэг тойргоос шууд сонгох эрхийн үндсэн дээр сонгогдоно. Хэрэв сонгуулийн дүнгээр нэр дэвшигчдийн хэн нь ч олонхын санал аваагүй бол хамгийн олон санал авсан хоёр нэр дэвшигчийг 14 хоногийн дотор хоёр дахь шатны санал

<sup>5</sup> Сонгуультай холбоотой хууль тогтоомжид 2016 оны Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2017 оны Эрүүгийн хууль, 2017 оны Зөрчлийн тухай хууль, 2011 оны Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хууль (сүүлд 2020 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан), 2006 оны Авлигын эсрэг хууль болон 2016 оны Хөгжлийн бэрхшээлтэй хүний тухай хууль тус тус нэмэгдсэн болно.

<sup>6</sup> Үүнд 1966 оны Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (ИУТЭТОУП), 1979 оны Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенц (ЭЯГБХУТК), 1965 оны Арьс үндсээр алагчилах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц (АУАУБХУТОУК), 2003 оны Авлигын эсрэг конвенц (АЭК), 2006 оны Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц (ХБХЭТК) багтана.

<sup>7</sup> Энэ заалт нь 2002 оны Венецийн комиссийн Сонгуультай холбоотой сайн туршилагын дурэмтэй нийцэж байна. Хэдийгээр ЕСТХ-д заасан боловч уг заалт нь зөвхөн Улсын Их Хурлын сонгууль болон сонгуулийн тогтолцоог өөрчлөхтэй хамааралтай юм. Мөн 2005 оны Сонгуулийн хууль, тогтоомжийн тогтвортой байдлын тухай Венецийн комиссийн тайлбар тунгах бичигтэй нийцэж байна.

<sup>8</sup> 2019 онд Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай, 2020 онд Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчийн сонгуулийн тухай шинэ хууль батлагдсан. АИХЭГ нь өмнө нь эдгээр хуулийг нэгтгэх тухай зөвлөсөн.

хураалтад оруулна. Хоёр дахь санал хураалтаар нэр дэвшигчдийн хэн нь ч үнэмлэхүй олонхын санал аваагүй тохиолдолд дахин сонгууль товлон явуулна. Нэг ч нэр дэвшигчийн төлөө санал өгөөгүй, тэмдэглээгүй саналын хуудсыг Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн дагуу хүчинтэй саналын хуудсанд тооцно гэж заасан бөгөөд тэмдэглээгүй саналын хуудасны тоо нь хоёр нэр дэвшигчдийн аль нэг нь олонхын санал авахаас сэргийлэх хэмжээний их бол дахин сонгууль явуулах нөхцөл бүрдэх юм.<sup>9</sup> Мөн Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулиар сонгогчдын нэрийн жагсаалтад бичигдсэн нийт сонгогчийн 50 хувь нь санал хураалтад оролцсоноор сонгуулийг хүчинтэйд тооцно. Уг хуулиар ирц хүрэхгүй бол 50 хувь нь оролцоогүй хэсэг тус бүрд нэмэлт санал хураалт явуулна. Ийм нөхцөл байдал урд өмнө нь Ерөнхийлөгчийн сонгуульд тохиолдож байгаагүй ба зөвхөн Улсын Их Хурлын сонгуульд тохиолдож байсан удаатай юм. Саналын эрх тэгш байдал, зохион байгуулалттай холбоотой бэрхшээл болон жижиг суурин газруудад саналын нууцлалыг алдагдуулах магадлалтай тул АИХЭГ-аас өмнө нь энэхүү ирцийн босго хувийг шүүмжилж байсан.

Үндсэн хуулийн цэц (ҮХЦ)-ийн 2021 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн шийдвэрээр ЕСТХ-ийн бүрэн эрхийн хугацаатай холбоотой зарим зүйл заалт нь Ерөнхийлөгчийг зөвхөн нэг удаа сонгоно гэсэн Үндсэн хуулийн заалттай нийцэхгүй байгааг тогтоосон.<sup>10</sup> Улсын Их Хурал Үндсэн хуулийн цэцийн уг шийдвэрийг хүлээн авсан тогтоол гаргаж урьд өмнө нь Ерөнхийлөгчөөр сонгогдож байсан хүмүүсийг, тэр дундаа Халтмаагийн Battulgыг дахин нэр дэвших эрхгүй болгосон байна. 2021 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр Ерөнхийлөгч Х.Баттулга “төрийн эрх мэдлийг үндсэн хуулийн бус аргаар булаан авах” оролдлого хийсэн тул МАН-ыг татан буулгах тухай захирамж гарган Монгол Улсын дээд шүүхэд хүргүүлжээ.<sup>11</sup> Улсын дээд шүүх энэ асуудлаар захирагааны болон шүүн таслах ямар нэг арга хэмжээ аваагүй талаар АИХЭГ-ын САТХ-нд мэдэгдсэн.

## V. СОНГУУЛИЙН БАЙГУУЛЛАГА

Ерөнхийлөгчийн сонгуулийг СЕХ, аймаг, нийслэлийн сонгуулийн 22 хороо (АНСХ), сум, дүүргийн сонгуулийн 339 хороо (СДСХ), 2,087 хэсгийн хороо (СХХ) гэсэн дөрвөн шатлалт бүтээцтэйгээр удирдан зохион байгуулав. Гадаад улсад байгаа иргэдээс санал авах ажлыг зохион байгуулахаар Гадаад хэргийн яамны дэргэд Төв комисс, мөн гадаадын 30 улсад суугаа дипломат төлөөлөгчийн газарт 44 салбар комисс байгуулагдсан. СЕХ-ны бүрэлдэхүүний зөвхөн нэг нь эмэгтэй гишүүн байсан ч сонгуулийн доод шатны хороодод эмэгтэйчүүдийн төлөөлөл сайн байлаа. Нийт ажилчдын 75 хувийг эмэгтэйчүүд эзэлж байв.

СЕХ нь байнгын ажиллагаатай төрийн байгууллага бөгөөд зургаан жилийн хугацаатай томилогдсон есөн гишүүний бүрэлдэхүүнтэй.<sup>12</sup> СЕХ нь нэр дэвшигчдийг бүртгэх, сонгуулийн бэлтгэл ажлыг зохион байгуулах, сонгуулийн өдрийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, саналын хураалтын нэгдсэн дунг гаргах, санал тоолох автоматжуулсан системийг ашиглах, засварлах үүрэгтэй. Одоогийн СЕХ-ны бүрэн эрх нь 2019 онд эхэлсэн ч дарга, нарийн бичгийн

<sup>9</sup> Өмнөх ерөнхийлөгчийн сонгуулиар, нийт саналын 8.2 хувь нь тэмдэглээгүй санал байв.

<sup>10</sup> Үндсэн хуулийн цэцийн [2021 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн шийдвэрээ](#) гаргахдаа хуулийг буцаан хэрэглэхгүй гэсэн зарчим нь Үндсэн хуульд мөрдөгдөхгүй тул Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт батлагдсан даруйдаа хүчин төглөдөр мөрдөгдөнө. Тодруулбал, ерөнхийлөгчид нэр дэвшигчдэд тавьж буй шалгуур, хязгаарлалтууд хуулийн нэмэлт, өөрчлөлт батлагдсан даруйдаа хэрэгжинэ.

<sup>11</sup> [Зарлигийг](#) харна уу (Монгол хэлээр).

<sup>12</sup> Хорооны таван гишүүнийг Төрийн байгуулалтын байнгын хорооны санал болгосноор УИХ, хоёрыг Ерөнхийлөгч, хоёрыг Дээд шүүх төрийн жинхэнэ албан хаагчдаас томилдог. СЕХ-ны орон тооны гишүүд болох дарга, нарийн бичгийн даргыг УИХ-ын даргын санал болгосноор сонгодог. Хорооны бусад гишүүн нь орон тооны бус байна.

дарга бүхий долоон гишүүнийг шинээр 2020 оны 1 болон 8 дугаар саруудад тус тус томилсон байна.

Сонгуулийн доод шатны хороодыг сонгууль бүрт шинээр байгуулах бөгөөд энэ удаагийн сонгуулийн хувьд хуулийн хугацаандаа багтан байгуулсан байна. Шинээр байгуулагдсан сонгуулийн хороодыг цахим болон биечилсэн сургалтуудад хамруулсан.<sup>13</sup> Нээлттэй цахим бүртгэл явуулсны дараа сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан, мэргэшсэн төрийн албан хаагчдын мэдээллийн сангаас сонгон сонгуулийн хороодын гишүүдийг шинээр томилжээ. АИХЭГ-ЫН өмнөх зөвлөмжийн дагуу доод шатны сонгуулийн хороодод гарч болзошгүй гажуудлыг арилгахын тулд СЕХ-ноос хороодын гишүүдийг сонгон шалгаруулахдаа сонгуулийн хороодод өмнө ажиллаж байсан туршлага, мэргэжлийн ёс зүйн хувьд цэвэр намтартай байх, төрийн албанд ажилласан жил зэрэг нэмэлт шалгууруудыг тогтоожээ. ЕСТХ-иар тухайн шатны Засаг даргын Тамгын газрын дарга нарыг АНСХ болон СДСХ-ны *дарааар томилох* зохицуулалттай байдаг. Сонгуулийн логистик асуудлыг орон нутгийн Засаг дарга хариуцдаг тул энэ томилгоо нь сонгуулийн доод шатны хороодыг намын нөлөөлөлд автуулах магадлалтай юм. Гэсэн хэдий ч САТХ-ны уулзсан ихэнх хүмүүс сонгуулийн хороодын мэргэжлийн ерөнхий чадавхид итгэлтэй байгаагаа илэрхийлж байсан.

Сонгуулийн байгууллага нь сонгуулийн бэлтгэлд хамаарах техникийн ажлуудыг үр дүнтэй, мэргэжлийн өндөр тувшинд удирдаж, хуулийн хугацааг мөрдөж ажиллалаа. СЕХ нь ээлжит хуралдаануудыг цар тахалтай холбоотой хорио цээрийн хязгаарлалтын улмаас ихэвчлэн цахимаар зохион байгуулав. Ихэнх шийдвэр, журмууд нь СЕХ-ны вэбсайт дээр цаг тухайд нь нийтлэгдэж байсан ч СЕХ-ны хуралдаан, тэр дундаа сонгуулийн нэгдсэн дүнг гаргах хуралдааны товыг урьдчилж нийтлэхгүй байсан нь оролцогч талууд уригдаагүй л бол идэвхтэй оролцох боломжоор хангагдаж чадаагүй байна. СЕХ нь өргөн нэвтрүүлгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, өөрийн болон нийтийн цахим хуудсаар дамжуулан үйл ажиллагааныхаа талаар олон нийтэд мэдээлж байсан. Гэсэн хэдий ч хуралдааны хуваарь болон тэмдэглэлийг нийтлээгүй нь тэдний ажлын ил тод байдлыг бууруулсан үзүүлэлт болсон ба олон нийтэд хамааралтай мэдээллийн хүртээмжтэй байдлын талаарх олон улсын стандарт, хэм хэмжээтэй зөрчилдөж байна.<sup>14</sup>

*Олон нийт сонирхож буй мэдээллийн ил тод байдал, хүртээмжийг хангахын тулд бүх шатны сонгуулийн байгууллагууд уулзалт, хуралдаанаа нээлттэй, ил тод зарчим баримтлан хийж, олон нийтэд урьдчилан зарлан мэдээлдэг байх нь зүйтэй. Мөн хурлаар хэлэлцэх асуудал, хурлын тэмдэглэл болон гаргасан шийдвэрүүдийг нэн даруй, тогтмол нийтэлж байх ёстой.*

Засгийн газраас СЕХ болон Улсын онцгой комисстай хамтран сонгуулийн үеэр Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх түр журмыг баталсан ба уг журмаар хамгаалалтын хэрэгсэл ашиглах, хүн хоорондын зайд барих, сурталчилгааны ажилд тавигдах шаардлагууд, санал авах байранд нэмэлт зохицуулалт хийх, цар тахалд өртсөн сонгогчдыг хэрхэх талаар зохицуулж өгсөн. Санал хураалт болохоос нэг өдрийн өмнө буюу 6 дугаар сарын 8-ны өдөр зөөврийн битүүмжилсэн хайрцгаар санал авах ажил явагдаж, гэрийн тусгаарлалт,

<sup>13</sup> АНСХ-г 3-р сарын 29, СДСХ-г 4-р сарын 9, СХХ-г 5-р сарын 10-ны өдрүүдэд тус тус байгуулсан. Сонгуулийн байгууллагын ажилчдад өгсөн сургалт ихэвчлэн цахим хэлбэрээр явагдсан. Хамгийн анхан шатны нэгж дээр энэхүү сургалтыг жижиг уулзалт, мэдээлэл олгох уулзалтуудаар дамжуулан орлуулан СДСХ-ны ажилчид өгсөн. Эдгээр уулзалтуудыг биечлэн зохион байгуулсан ба ихэнх нь сонгуулийн хугацаанд гарсан өөрчлөлт, нэмэлт мэдээллийг тодруулан, нэмэлт мэдээлэл авсан.

<sup>14</sup> [2011 оны НҮБ-ЫН ИУТЭТОУП-ЫН Ерөнхий тайлбар по.34-ийн 19-р зүйл Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө хэсэгт](#), “Мэдээлэл олж авах эрхийг хэрэгжүүлэхийн тулд олон нийтийн ашиг сонирхолд нийцсэн Засгийн газрын мэдээллийг Гишүүн улсууд олон нийтэд эзэмшиүүлэхийг идэвхийлэх нь зүйтэй. Ийм мэдээлэлийг хялбар, шуурхай, үр дүнтэй, практик аргаар олж авах боломжийг хангахын тулд Гишүүн улсууд бүхий л хүчин чармайлтаа зориулбал зохино”.

тусгаарлан ажиглах байр, мөн эмнэлгийн байгууллагуудад эмчлүүлж байгаа 7,051 иргэн болон зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгөх эрх бүхий 18,568 сонгогч саналаа өглөө.<sup>15</sup> КОВИД-19 шинжилгээний хариу нь эерэг гарсан болон хуульд заасан хугацаанаас хойш гэрийн тусгаарлалтад байгаа, мөн хөл хорионд орсон сонгогчид санал өгөх боломжгүй байв. Эдгээр асуудлыг зохицуулах тодорхой журам байгаагүйн улмаас СЕХ-ны мэдээлснээр 1,946 эрх бүхий сонгогчид саналаа өгөх боломжгүйд хүрсэн байх магадлалтай юм.

Сонгуулийн үйл явцын талаар оролцогч талуудад мэдээлэл өгөх, СЕХ-ны үйл ажиллагааг сайжруулах зорилгоор 2021 оны эхээр Сонгогчийн боловсрол, сургалтын төвийг байгуулсан. Санхүүгийн болон хүний нөөцийн хомстлын улмаас сонгогчийн боловсролд оруулах СЕХ-ны оролцоо, хувь нэмэр хязгаарлагдмал байсан ч СЕХ иргэний нийгмийн байгууллага (ИНБ)-уудтай нягт хамтран ажилласан нь сонгогчийн боловсрол, мэдээлэлтэй холбоотой материал боловсруулахад ихээхэн хувь нэмэр оруулсан.<sup>16</sup> Түүнчлэн СЕХ нь Сонгогчдын боловсрол төв ТББ-тай хамтран сонгогчийн эрх, сонгогчийн мэдээлэл, санал тоолох төхөөрөмж, нийтээр дагаж мөрдөх эрүүл мэндийн хариу арга хэмжээ зэрэг сонгуулийн үйл явцын тухай гарын авлагыг монгол болон казак хэл дээр хэвлүүлжээ.

2016 онд батлагдсан Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль нь 2006 оны Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц (ХБХЭТК)-д заасны дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг сонгуульд саналаа нууцаар, бие даан өгөх боломжоор хангадаг.<sup>17</sup> ЕСТХ-иар санал авах байр бүрд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан нэгээс доошгүй санал өгөх бүхээгийг тусгайлан тоноглож бэлтгэсэн байна. Мөн саналаа биечлэн өгөх чадваргүй сонгогч өөрийн итгэмжилсэн сонгуулийн эрх бүхий иргэний туслалцаатайгаар саналаа өгч болно гэж заасан байдаг. Хэд хэдэн ИНБ-уудын дэмжлэг, нягт хамтын ажиллагааны үр дүнд СЕХ нь сүүлийн жилүүдэд сонсголын болон харааны бэрхшээлтэй хүмүүст зориулан сонгуулийн мэдээллийн хүртээмжийг сайжруулах, тухайлбал өөрийн цахим хуудас дээрх бичвэрийн тохиргоог хийх, хэвлэмэл материалыг аудио хувилбар болон брайль үсгээр хэвлэх, сонгогчдын боловсролд зориулсан видео бичлэгүүддээ хадмал орчуулга оруулах, дохионы хэлний орчуулга ашиглах зэргээр хүчин чармайлт гаргалаа.

## VI. САНАЛ ТООЛОХ ТӨХӨӨРӨМЖ

Сонгуулийн бүх хэсгийн хороо нь санал тоолох төхөөрөмж (СТТ) болох Доминион вөүтинг системс компанийн ImageCast Precinct optical scan буюу Имиж Касти дүрс буулган санал тоолох төхөөрөмжөөр тоноглогдсон. Эдгээр төхөөрөмжийг 2012 онд худалдан авсан ба бүх шатны сонгуульд улс даяар хэрэглэж ирсэн. СТТ-ийг сонгуулийн өдөр интернет сүлжээнээс холболтыг нь салган ашигладаг ба санал хураалт дууссаны дараа сүлжээнд дахин холбож secure virtual private network буюу хамгаалаттай виртуал хувийн сүлжээ (ВХС)-ээр дамжуулан СЕХ-нд урьдчилсан дүнг дамжуулдаг байна.

ЕСТХ-иар хяналтын тооллогыг бүх санал авах байранд хийхээр хуульчилсан ба, өмнөх хуулинд зааснаас олон тооны буюу нийт санал авах байрны 50 хүртэл хувьд хяналтын тооллого хийхээр заасан. СЕХ нь СТТ-ийн ажиллагааны ил тод байдал, үүний талаарх олон нийтийн ойлголтыг дээшлүүлэхийн тулд нэр дэвшигчид болон иргэний нийгмийн төлөөлүүдийг байлцуулан

<sup>15</sup> Сонгогчид нь эрүүл мэндийн шалтгаанаар санал авах байранд өөрийн биеэр очиж санал өгөх боломжгүй, хорих байгууллагад хоригдож буй, эсвэл сонгуулийн өдөр дайчлагдан ажиллаж буй төрийн албан хаагч гэсэн ангилалд багтаж буй бол 6-р сарын 2 болон 5-ны дотор амжин зөөврийн битүүмжилсэн хайрцгаар саналаа өгөхөөр бүртгүүлэх боломжтой.

<sup>16</sup> Залуу сонгогчдын сонгуулийн оролцоог нэмэгдүүлэх зорилго бүхий иргэний нийгмийн байгууллагын үйл ажиллагаа нь гэнэт сонгуулийн өмнө зогссон талаар АИХЭГ-ын САТХ-д мэдээлсэн.

<sup>17</sup> Монгол Улс ХБХЭТОУК-д 2008 онд соёрхон баталж, 2009 оноос нэгдэн орсон.

төхөөрөмжийг хэд хэдэн шатанд туршиж үзсэн. Дээрх төлөөлөгчид төхөөрөмжид бие даан туршилт хийх эрхтэй байснаас гадна тэднийг ерөнхийлөгчийн сонгуулийн эх код болон системийн тохируулгыг дэлгэцэн дээр үзэхийг урьсан ч техникийн баримт бичигтэй шууд танилцах эрх олгоогүй. Эдгээр туршилтуудыг СЕХ баримтжуулаагүй мөн нийтлээгүй байна. СТТ-ийн үйл ажиллагааг шалгасан туршилтуудын талаарх мэдээлэл, үр дүнг ганцхан МИДАС (Монголын мэдээлэл, хөгжлийн холбоо) ТББ олон нийтэд нээлттэй нийтэлсэн байв. АИХЭГ-аас өгсөн өмнөх зөвлөмж байгаа ч, СТТ-д хараат бусшалгалт, баталгаажуулалт хийх шаардлагатай гэж хуулинд заагаагүй нь төхөөрөмжийн аюулгүй, үнэн зөв байдалд эргэлзээ төрүүлж болзошгүй. Гэхдээ бүх төхөөрөмжүүдийг СЕХ-той хамтран төрийн байгууллага баталгаажуулдаг байна.<sup>18</sup> Цөөн тооны улс төрчид төхөөрөмжийн үнэн зөвд эргэлзэж байсан ч АИХЭГ-ын САТХ-ны гишүүдтэй уулзсан хүмүүс СТТ-д итгэж байгаагаа илэрхийлэв.

*Сонгуулийн төхөөрөмжид итгэх итгэлийг нэмэгдүүлэхийн тулд хараат бус, гуравдагч этгээдээр санал тоолох төхөөрөмжийг баталгаажуулах талаарх зохицуулалтыг хуульд тодорхой заах нь зүйтэй. Сонгуулийн байгууллага нь санал тоолох төхөөрөмжид хийж буй бүх шинэчлэл, туршилтийг баримтжуулж, холбогдох бүх мэдээлэл, тэр дундаа баримтжуулах үйл явц, өөрчлөх хүсэлтүүд болон өөрчилсөн үйлдлүүдтэй холбоотой мэдээллийг олон нийтэд нээлттэй байлгах нь зохистой.*

## VII. СОНГОГЧИЙН БҮРТГЭЛ

Үндсэн хуулинд зааснаар сонгуулийн өдөр 18 насанд хүрсэн бүх иргэн санал өгөх эрхтэй. Харин ЕСТХ-иар шүүхээр эрх зүйн чадамжгүй нь тогтоогдсон, оюуны болон сэтгэцийн бэрхшээлтэй, үйлдсэн гэмт хэргийн ангиллаас үл хамааран хорих ял эдэлж буй хүмүүсийн санал өгөх эрхийг хязгаарласан заалтуудыг хэвээр үлдээсэн нь олон улсын өмнө хүлээсэн үүрэг болон АИХЭГ-ын өмнөх зөвлөмжүүдтэй зөрчилдсөн хэвээр байна.<sup>19</sup>

*Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн зорилго, зорилттой бүрэн нийцүүлсэн хууль эрх зүйн орчин бүрдүүлэхийн тулд оюуны болон сэтгэцийн бэрхшээлтэй холбоотой санал өгөх эрхийг хязгаарласан бүх заалтыг хүчингүй болгох хэрэгтэй. Хорих ял эдэлж буй бүх этгээдийн санал өгөх эрхийг хязгаарлаж буй заалтыг эргэн харж, олон улсын өмнө хүлээсэн үүрэгт нийцүүлэх нь зүйтэй.*

Сонгогчдын нэрийн жагсаалтыг Улсын бүртгэлийн ерөнхий газар (УБЕГ)-ын иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд үндэслэн гаргадаг. Уг жагсаалт нь тогтмол шинэчлэгддэг ба, иргэний хувийн болон биометрийн мэдээллийг агуулдаг.<sup>20</sup> Сонгогчийн мэдээллийг сонгуулийн өдөр санал авах байруудад сонгогчийн биометрийн мэдээлэл буюу хурууны хээ унших төхөөрөмжөөр баталгаажуулна. Сонгогчдын нэрийн жагсаалтыг УБЕГ-ын цахим хуудсанд 4

<sup>18</sup> Тагнуулын ерөнхий газар болон Харилцаа холбооны зохицуулах хороо.

<sup>19</sup> [Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай 2013 оны конвенцийн Хорооны захидал харилцааны 4/2011](#) тоот хэсгийн 9.4-т “29-р зүйл нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст ямар нэгэн хязгаарлалт тавиагүйгээс гадна аль нэг бүлгийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хасахыг зөвшөөрөхгүй. Иймд санал өгөх эрхийг оюуны болон нийгмийн сэтгэцийн бэрхшээлтэй гэж үзсэн эсвэл батлагдсаны үндсэн дээр хассан, тэр дундаа хувь хувь хүний үнэлэмжийн дагуу хязгаарлалт хийх нь Конвенцийн 2-р зүйлд заасны дагуу хөгжлийн бэрхшээлтэй гэж ялгарварлан гадуурхах явдал юм” гэжээ. [Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын 2006 оны конвенцийн](#) 12, 29-р зүйлийг үзнэ үү. Мөн НҮБ-ын Хүний эрхийн комиссын, [Yevdokimov v. Russian Federation, 2011 оны 5 дугаар сарын 9](#), хэргийг харна уу. Үүнд гэмт хэргийн хүнд байдлыг харгалзахгүйгээр эрүүгийн ялыг үндэслэн сонгох эрхийг бүхэлд нь хязгаарлах нь ИУТЭОУП-ын 25 дугаар зүйлийг зөрчсөн гэж тус хороо үзжээ.

<sup>20</sup> Гадаад улсад байгаа санал хураалтад оролцохыг хүссэн сонгогчид 4-р сарын 20-оос 5-р сарын 9-ний хооронд оршин суугаа орныхоо дипломат төлөөлөгчийн газарт бүртгүүлэх шаардлагатай байв. ГХЯ-ны мэдээлснээр 5-р сарын 30, 31-нд 7,394 сонгогч саналаа өгөхөөр бүртгүүлжээ.

дүгээр сарын 1-нд урьдчилсан байдлаар нийтлэв. Сонгогчид цахим санд нэвтрэн өөрсдийн мэдээллээ баталгаажуулахын зэрэгцээ өөрсдийн хаяг дээр бүртгүүлсэн бүх хүний бүртгэлийг шалгаж нягтлах боломжтой байсан нь энэ удаагийн сонгуульд орсон нэг шинэ зүйл байлаа. Сонгогчдын нэрийн жагсаалтыг 5 дугаар сарын 15-ны дотор СХХ-дод цаасан хэлбэрээр хүргүүлсний дараа бүртгэлийн мэдээлэлд баталгаажуулалт хийх боломжтой байсан ба 5 дугаар сарын 26-ныг хүртэл өөрчлөлт оруулах хүсэлт гаргах боломжтой байсан.

Гадаад түр оршин суугч, санал хураалтад оролцохыг хүссэн сонгогчид 4 дүгээр сарын 20-оос 5 дугаар сарын 9-ний хооронд оршин суугаа орныхоо дипломат төлөөлөгчийн газарт бүртгүүлэх шаардлагатай байв. ГХЯ-ны мэдээлснээр 120,000 орчим санал өгөх насын иргэд гадаадад оршин суудаг ч 7,394 сонгогч саналаа өгөхөөр бүртгүүлсэн байна. Гадаадад оршин сууж байгаа сонгогчдын бүртгэл, ирцийг дээшлүүлэхэд чиглэсэн мэдээллийг нэмэгдүүлэх шаардлагатай байсан талаар иргэний ажиглагч бүлгүүд АИХЭГ-ЫН САТХ-нд мэдээлж байлаа. Гадаад улсад санал авах ажиллагаа 5 дугаар сарын 30, 31-ний өдрүүдэд дипломат төлөөлөгчийн газаруудад зохион байгуулагдсан.

Өөрийн бүртгэлтэй санал авах байранд саналаа өгөх боломжгүй сонгогчид өөр сонгуулийн хэсэг рүү түр шилжих хүсэлт гаргаж болох ч бүртгэлтэй хэсгийн хороондоо шилжих хүсэлтээ биечлэн өгсний дараа шинэ сонгуулийн хэсгийн хороонд очижшилжүүлгээ баталгаажуулах ёстай. Коронавируст халдварт /КОВИД-19/-ын цар тахалтай холбоотой дотоодын шилжилт хөдөлгөөнийг хязгаарласан тул энэхүү зохицуулалт нь бүртгүүлсэн газраасаа хол байгаа, буцаж очих боломжгүй болсон ажилчид, оюутнууд саналаа өгөхөд хүндрэл бэрхшээл үүсгэж байсан. Нийтдээ 22,392 сонгогчид бүртгэлээ түр шилжүүлэх хүсэлт гаргасан байна. ЕСТХ-нд иргэдийн хаягийн өөрчлөлт, шилжилт хөдөлгөөнийг санал авах өдрөөс 60 хоногийн өмнө зогсоох зохицуулалт байдаг. Гэхдээ Ерөнхийлөгчийн сонгууль нь сонгуулийн нэг тойротг явагддаг учир дээрх зохицуулалтын үндэслэл, шалтгаан нь тодорхой бус бөгөөд сонгогчдод илүү хүндрэл учруулах магадлалтай.

*Санал авах байрнаасаа хол байгаа иргэдийн санал өгөх эрхийг хангах үүднээс сонгогчийн түр шилжилт хийх үйл явцыг хялбаршуулах нь зүйтэй.*

Сонгогчдын нэрийн эцэслэсэн жагсаалт 6 дугаар сарын 5-наар хаагдсан бөгөөд нийтдээ 2,040,556 сонгогч бүртгэгджээ.<sup>21</sup> ЕСТХ нь сонгогчдын нэрийн жагсаалтад өөрчлөлт оруулах хугацаа хэтэрсний дараа хорих ангиас суллагдсан, гадаад улсаас эргэн ирсэн зэрэг сонгогчдын түр хасалтыг сэргээх тусгайлсан зохицуулалтгүй боловч санал авах өдөр нотлох баримтад үндэслэн түр хасалт хийлгэсэн сонгогч санал өгөх эрхээ харьяа СХХ-ndoо сэргээн саналаа өгөх боломжтой байв. Санал авах өдөр сонгогчдын нэрийн жагсаалт дахь санал өгөх эрх бүхий сонгогчдын тоо 2,041,985 хүрсэн байна.<sup>22</sup>

АИХЭГ-ЫН САТХ-той уулзаж ярилцсан хүмүүс сонгогчдын нэрийн жагсаалт үнэн зөв бөгөөд, бүх сонгогчдийг ялгаварлахгүйгээр хамруулсан гэдэгт итгэж буйгаа илэрхийлж байсан. Зарим хүмүүс үндэсний хаягжилтийн бүртгэлийн системд олон жилийн турш явж ирсэн алдаа дутагдлыг онцолж, зарим нэг газарт эргэлзээ төрүүлэхүйц бүртгэлүүд илэрсэн ч гэлээ санаа зовоо том асуудал биш гэж хэлж байв. Нэр дэвшигчид нийт сонгогчдын эцэслэн гаргасан нэрийн жагсаалтын цахим хувилбарыг санал авах өдрөөс 3 хоногийн өмнө авах эрхтэй байсан бол иргэний ажиглагчид СХХ бүрээс тус хороонд хамаарах сонгогчдын нэрийн жагсаалттай

<sup>21</sup> Сонгогчийн нэрийн жагсаалтад орсон нийт сонгогчийн тоо 2,151,329, үүнээс 110,773 сонгогчийг шаардлага хангаагүй тул шүүхийн шийдвэрээр эрх зүйн чадамжгүй нь тогтоогдсон, хорих ял эдэлж байгаа, гадаадад 60-аас дээш хоног байсан зэрэг шалтгаанаар түр хассан байна.

<sup>22</sup> Сонгогчдын нэrsийн эцэслэн гаргасан жагсаалт дахь санал өгөх эрх бүхий сонгогчдын тоо, гадаад улсад бүртгүүлсэн сонгогчдын нийтдээ 2,049,379 байв.

танилцах боломжтой байв. Сонгогчдын нэрийн жагсаалтын мэдээлэлтэй биечлэн шалгах хугацаа богино байсан, нийт сонгогчдын нэрийн жагсаалттай танилцахад тавьж буй хязгаарлалтууд зэрэгээс үүдэн нэрийн жагсаалтад хараат бус, бие даасан хяналт шалгалтыг хийх боломжийг хааж байв.

*Сонгогчдын бүртгэлийн үйл явцад итгэх итгэлийг нэмэгдүүлэх, хувийн мэдээллийн бүрэн бүтэн байдлыг хангахын тулд улс төрийн намууд болон иргэний ажиглагчдад бие даан шалгах хангалттай хугацаа өгч, сонгогчдын нэрийн нэгдсэн жагсаалттай танилцах боломжийг олгох ёстой.*

### VIII. НЭР ДЭВШИГЧИЙН БҮРТГЭЛ

ECTХ-д нэмэлт өөрчлөлт оруулсан хэдий ч нэр дэвших эрхэд хэт хязгаарлагдмал хэд хэдэн заалт хэвээр үлдсэн байна. Эрх бүхий нэр дэвшигч нь Монгол улсын харьят эцэг, эхээс төрсөн, санал авах өдрөөс өмнөх таваас доошгүй жил Монгол Улсад оршин суусан байх ёстой. Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр насны шалгуурыг 45 нас байсныг 50 болгон нэмэгдүүлсэн. Эрх бүхий нэр дэвшигч нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон өр, зээл болон хугацаа хэтэрсэн албан татварын өр төлбөргүй байх ёстой. ECTХ-нд ял эдлээгүй ч шүүхээр авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдсон ч ял эдлээгүй хүн нэр дэвшихийг хориглосон зохицуулалт нэмсэн ба сэтгэцийн эмгэг, эрх зүйн чадамжгүй нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон хүн нэр дэвшихийг хориглосон заалтыг хэвээр үлдсэн. Өмнө нь өгч байсан АИХЭГ-ЫН зөвлөмжийн дагуу цэргийн алба хаагаагүй, ял шийтгүүлж байсан зэрэг нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзах үндэслэл бүхий заалтуудыг дээрх шинэчлэн баталсан хуульд оруулаагүй байна. Хэдийгээр зөвлөмжийг тусгаж өгсөн ч, нэр дэвших эрхэд тавьж буй шалгуур нь хэт хязгаарласан хэвээр үлдсэн бөгөөд ЕАБХАБ-ЫН өмнө хүлээсэн үүрэг амлалтууд болон олон улсын бусад хэм хэмжээтэй зөрчилдсөн хэвээр байна.<sup>23</sup>

*Нэр дэвших эрх, тэр дундаа хөгжлийн бэрхшээлтэй байдал, оришин суугаа газар, гарал үүсэлтэй холбоотой хязгаарлалтуудыг олон улсын хэм хэмжээтэй нийцүүлэхээрэргэн харах нь зүйтэй.*

Улсын Их Хуралд суудалгүй нам болон хувь хүн бие даан нэрээ дэвшүүлэх эрхгүй байгаа нь АИХЭГ-ЫН өмнө нь өгч байсан зөвлөмжүүдтэй зөрчилдсөн, ЕАБХАБ-ЫН өмнө хүлээсэн үүрэгтэй нийцэхгүй байхын зэрэгцээ сонгогчдын сонголтыг хязгаарлаж байна. Түүнчлэн, нэр дэвшихээр зэхжэй буй төрийн албан хаагч ээлжит сонгуулийн жил эхлэхээс өмнө, нэр дэвших ажиллагаа явагдахаас хэдэн сарын өмнөөс эрхэлсэн ажил, төрийн албан тушаалаасаа чөлөөлөгдсөн байх зэрэг шаардлагууд нь нэр дэвших эрхэд хэрэгцээгүй саад бэрхшээлийг бий болгож байна.

*Улсын Их Хуралд суудалгүй нам болон хувь хүн бие даан нэрээ дэвшүүлэх эрхийг хангах зорилгоор хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах нь зүйтэй.*

<sup>23</sup>

Иргэний болон төрийн эрхийн олон улсын пакт (ИУТЭОУП)-ын 25 дугаар зүйлд өгсөн 1996 оны НҮБ-ын Хүний эрхийн хорооны 25 дахь Ерөнхий тайлбарын 15 дахь хэсэгт “Сонгогдох эрх эдлэх эрхтэй хүмүүсийг боловсрол, оршин суугаа газар эсхүл гарал үүсэл, улс төрийн харьялал зэрэг үндэслэлгүй эсхүл ялгавралан гадуурхасан шинжтэй шаардлагуудыг тавьжжасах ёсгүй” гэж заасан байдаг. 1990 оны ЕАБХАБ-ЫН Копенгагены баримт бичгийн 7.5 дахь хэсэгт “Гишүүн улсууд нь иргэдийнхээ дангаараа болон улс төрийн нам, байгууллагаар дамжуулан улс төрийн болон төрийн албан тушаал хаших эрхийг ялгаврлан гадуурхагдалгүйгээр хүндэтгэх” ёстой хэмээн заасан байна. Мөн 1990 оны ЕАБХАБ-ЫН Копенгагены баримт бичгийн 24 дэх хэсэг, 2002 оны Венецийн комиссийн “Сонгуулийн үйл ажиллагаан дахь сайн туршлагын” дүрмийн II.1.b хэсгийг харна уу.

Төрийн албан хаагчид нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэх хүртэл эрхэлсэн ажил, албан тушаалаасаа чөлөөлөгдөх шаардлагагүй байх ёстой.

ECTХ-нд заасны дагуу Улсын Их Хуралд суудал бүхий улс төрийн намууд нэр дэвшүүлэх ажиллагааг санал авах өдрөөс 40 хоногийн өмнө эхлүүлж, гурав хоногийн хугацаанд дуусгах ёстой – энэ удаагийн сонгуулийн хувьд 4 дүгээр сарын 30-наас 5 дугаар сарын 2 хүртэл таарч байгаа ба үүний дараа СЕХ нэр дэвшигчийг бүртгэх эсэх асуудлыг гурав хоногийн дотор шийдвэрлэнэ. Хуулиар нэр дэвшүүлэхтэй холбоотой баримт бичиг алдаатай бол нэг удаа засах боломж олгодог. Нэр дэвшигч хангасан байх шалгуур, бүрдүүлэх баримт бичгийн хэмжээтэй харьцуулахад нэр дэвшүүлэх болон нэр дэвшигчийг бүртгэх хугацаа хэт богино бөгөөд сонгуулийн үйл ажиллагааныхуваарийн хувьд харьцангуй хожуу байгаа нь нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзсан тохиолдолд шүүхээр үр дүнтэй шийдвэрлүүлэх эрхийг зөрчихөөр байна (*Өргөдөл, голдол хэсгийг харна уу*). СЕХ нэр дэвшүүлсэн дөрвөн хүнээс гурвыг нь 5 дугаар сарын 7-ны өдөр бүртгэсэн.

*Сонгуулийн ерөнхий хороонд нэр дэвшигчийг бүртгэх, түүнтэй холбоотой шүүхэд гаргасан гомдолыг эцэслэн шийдвэрлэхэд хангалттай хугацаа олгох үүднээс нэр дэвшүүлэх хугацааг уртасган, сонгуулийн үйл ажиллагааны хуанлид эрт оруулах зохицуулалтыг хийж өгөх нь зүйтэй.*

СЕХ-нд бүртгүүлэхийн тулд эрх бүхий нэр дэвшигчид сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Үндэсний аудитын газар (YAG)-т санал авах өдрөөс 37-оос доошгүй хоногийн өмнө хүргүүлэн төсвийн боломж болон улсын “тогтвортой хөгжлийн зорилт”-д нийцэж буй эсэхэд дүгнэлт гаргуулах ёстой. YAG-ын дүгнэлт гарсны дараа уг сонгуульд өрсөлдөж буй нэр дэвшигчид бүгд мөрийн хөтөлбөрөө дүгнэлтийн дагуу засаж YAG-т дахин хүргүүлсэн байна. Хуулинд зааснаар, YAG-ын дүгнэлт нь сөрөг гарсан нэр дэвшигчийг СЕХ бүртгэлээсээ хасах эрх олгосон нь иргэний нэр дэвших эрх болон сонгуулийн сурталчилгаа хийх эрх чөлөөнд хэт халдаж байна.<sup>24</sup>

*Нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөр тодорхой бодлоготой нийцэж буй эсэхэд Үндэсний аудитын газар дүгнэлт гарган баталгаажуулдаг шаардлагыг болиулах хэрэгтэй.*

## IX. СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГАА

Сонгуулийн сурталчилгаа албан ёсоор 5 дугаар сарын 24-ны өдрөөс 6 дугаар сарын 7-ны өдрийн хооронд болж өнгөрлөө. ECTХ-иар 19 хоногийн турш үргэлжилдэг байсан сонгуулийн сурталчилгааны хугацааг 15 болгон богиносгосон нь цар тахлын улмаас сонгогчиддоо хүрч ажиллах боломж аль хэдийнээ хумигдаад байсныг улам хязгаарласан алхам болсон гэж зарим улс төрийн намууд тэмдэглэв. Иймэрхүү зохицуулалт нь дээрх хугацаанд улс даяар ажиллах бүрэн боломж, нөөцтэй олон жил болсон улс төрийн намуудад илүү ашигтай байсан юм.

ECTХ нь нэр дэвшигчид сонгуулийн сурталчилгааны ажлаа хэрхэн зохион байгуулах, сурталчилгаанд ашиглах материал, хөрөнгө, сонгуулийн штабын бүтэц, хэмжээг хатуу тогтоож, зөвшөөрөгдсөн үйл ажиллагааг жагсааж өгсөн зэргээр нарийн зааварласан шинжтэй байна. Сонгогчдод мөнгө болон эд зүйл тараах, олон нийтийг хамарсан үзвэр, урлагийн тоглолтын үеэр сонгуультай холбоотой сурталчилгаа явуулах зэргийг хуулиар хориглосон нь сайшаалтай. Түүнчлэн энэ хуулинд сонгуулийн жилд сонгуульд оролцогчийг байхыг уриалахыг хуулиар хориглосон нь олон улсын хэм хэмжээтэй зөрчилдөж байгаагийн дээр олон нийтийн санал

<sup>24</sup> [ИУТЭОУП-ын 2017 онд Монгол Улсад хийсэн ажиглалтын дүгнэлтийн](#) 39 болон 40 дүгээр хэсгийг харна уу.

асуулгын дүнг хэвлэн нийтлэхийг хуулиар хориглосон нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг хэт хязгаарлаж байна.<sup>25</sup> Мөн ирц хүрээгүйн улмаас нэмэлт санал хураалт явуулах, сонгууль хүчингүйд тооцогдсон тохиолдолд дахин сонгууль явуулах болон хоёр дахь шатны санал хураалт явуулах зэрэг нөхцөлүүдэд сонгуулийн сурталчилгаа хийхийг хориглосон байдаг.

*Сонгуулийн сурталчилгаа явуулахад зөвшиөөрөгдсөн төрлийн үйл ажиллагаа, хэрэглэж болох хөрөнгө, нөөцийг [нэрлэлгүй] хэт хязгаарласан зохицуулалтыг багасгаж хуулийг өөрчлөн батлах ёстой. Мөн сонгуулийн нэг ба хоёр дахь шатны хооронд сурталчилгаа явуулахыг зөвшиөөрөх нь зүйтэй.*

Энэ удаагийн сонгуулийн сурталчилгаа ерөнхийдөө даруухан болж өндөрлөсөн. Улаанбаатар хотноо сонгуулийн сурталчилгааны самбар, зурагт хуудас болон бусад материалууд бараг харагдаагүй. Бүх нэр дэвшигчид ямар нэг хөндлөнгийн оролцоогүйгээр сурталчилгаагаа чөлөөтэй явуулах боломжтой байсан ч нөөц, бололцооны илт ялгаатай байдал ажиглагдаж байсан. Нэр дэвшигчид зарим олон нийтийг хамарсан уулзалт, сонгуулийн арга хэмжээг зохион байгуулсан боловч ерөнхийдөө аль болох сонгогчидтой шууд харилцахгүй байх, нийтийн цахим сүлжээ, ялангуяа Фэйсбуүк ашиглан сурталчилгаагаа явуулахыг зорьж байлаа. АИХЭГ-ын САТХ-ны ажигласан сурталчилгааны арга хэмжээнүүд КОВИД-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх журмыг хүндэтгэн, ЕСТХ-д заасан шаардлагын дагуу дохионы хэлний хэлмэрчтэй явагдсан.

Нэр дэвшигчид Ерөнхийлөгчийн бүрэн эрхэд хамаарах гадаад бодлого, шүүх эрх мэдлийн асуудлаас гадна эдийн засаг, хөрөнгө оруулалт, уул уурхайн нөөц, нийгмийн халамж болон цар тахалтай холбоотой арга хэмжээ зэрэг Ерөнхийлөгчийн эрх мэдлээс гадуурх асуудлаар сурталчилгаагаа байнга явуулж байсан юм. Эмэгтэйчүүд, ЛГБТИ эрх болон хүйсийн тэгш эрхтэй холбоотой асуудлууд сонгуулийн сурталчилгаанд дурдагдаагүй бөгөөд нэр дэвшигчдийн мөрийн хөтөлбөрт бараг тусгагдаагүй байсан.<sup>26</sup> Өмнөх ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр тэмдэглээгүй саналын хуудас өгөх сонголтыг эсэргүүцлийн хэлбэр, тактик болгон ашиглаж байсан нь энэ удаагийн сонгуулийн сурталчилгааны сүүлийн өдрүүдэд эрчимжиж, түүгээр ч барахгүй зарим сөрөг хүчний төлөөлөл үүнийг идэвхжүүлэн дэмжиж байлаа.<sup>27</sup> Санал авах өдрөөс 4 хоногийн өмнө ЗХЭЭ-ээс нэр дэвшигч Д.Энхбат КОВИД-19 өвчний халдварт авсан тухайгаа зарлан сурталчилгааны үйл ажиллагаануудаа зогсоосон, МАН-ын нэр дэвшигч У.Хүрэлсүх сонгуулийн сурталчилгааны хаалтын арга хэмжээгээ цуцласан бол АН-ын нэр дэвшигч С.Эрдэнэ төлөвлөгөөнийхөө дагуу үргэлжлүүлсэн байна.

ЕСТХ-нд сонгуулийн сурталчилгаанд цахим орчин ашиглах асуудлыг тусган, хяналт тавих эрхийг зохицуулах эрх бүхий хэд хэдэн байгууллагууд хамтран хэрэгжүүлэхээр тусгажээ. Мөн хуулинд нэр дэвшигч бүр сурталчилгаа явуулах зорилгоор дээд тал нь нэг цахим хуудас, олон нийтийн сүлжээний нэг хаягтай байхыг зөвшөөрсөн. Энэхүү хязгаарлалтын зорилго нь тодорхойгүй бөгөөд АИХЭГ-ын САТХ-ны ажигласнаар нэр дэвшигч бурийг дэмжсэн хэд хэдэн

<sup>25</sup> ИУТЭТОУП-ын 19 дүгээр зүйлд “[Үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл түгээх, хүлээн авах эрх чөлөө] тодорхой хязгаарлалттай байж болох ч эдгээр нь зөвхөн хуульд заасан бөгөөд дараах зайлшгүй шаардлагаас үүдэн гарсан байх ёстой: (а) бусдын эрх, нэр хүндийг хүндэтгэх; (б) үндэсний аюулгүй байдал, нийтийн дэг журам (ordre public), хүн амынху эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах. [2011 оны НҮБ-ын ИУТЭТОУП-ын19-р зүйлд өгсөн 34 дэх Ерөнхий тайлбар: Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө](#), 28-р догол мөрд “Сонгогчыг айлган сурдуулэх, албадлагын шинжтэй илэрхийлэх хэлбэрээс хамгаалахыг зөвшөөрч болох ч ийм хязгаарлалт нь улс төрийн мэтгэлцээнд саад болохгүй, тухайлбал, албадлагын бус санал хураалтыг бойкотлохыг уриалж байна” гэж заасан.

<sup>26</sup> Ганцхан МАН жендерийн хэвшмэл ойлголтыг таслан зогсох, гэр бүлийн хучирхийллээс урьдчилан сэргийлэх агуулга бүхий нэг зүйлийг төрийн хөтөлбөртөө тусгасан байна.

<sup>27</sup> Санал авах өдөр, тэмдэглээгүй саналын хуудас хүчинтэй саналын 5.92 хувийг эзэлж байв.

Фэйсбүүк хуудас байсан төдийгүй зарим нь төлбөртэй улс төрийн сурталчилгаа явуулж байсан. Харилцаа холбооны зохицуулах хороо (ХХЗХ) сонгуультай холбоотой контентод хяналт тавихаар Фэйсбүүктэй хамтын ажиллагаа эхлүүлсэн боловч энэхүү хамтын ажиллагааны нөхцөл, хэрэгжүүлэх боломжит механизмуудын талаар олон нийтэд мэдэгдээгүй юм.

АИХЭГ-ын САТХ-ны ажигласнаар голдуу МАН, цөөн тохиолдолд АН-ын сонгуулийн сурталчилгааг сонгуулж болон улс төрийн томилгоот төрийн албан хаагчид дэмжиж, албан тушаалаа ашиглан өөрсдийн тойрогт сурталчилгаа хийсэн хэд хэдэн тохиолдол гарсан. Хэдийгээр хуулинд төрийн албан хаагчдыг сонгуулийн сурталчилгаанд оролцохыг зөвшөөрдөг ч, үүрэг болон сонгуулийн сурталчилгааны хоорондын ялгаа, заагийг нарийн тодорхойлж өгөөгүй байна.<sup>28</sup> АИХЭГ-ын САТХ-той уулзсан зарим хүмүүс төрийн албан хаагчид болон төрийн захиргааны нөөцийг сонгуулийн сурталчилгаанд урвуулан ашиглаж байгаа асуудалд санаа зовниж буйгаа илэрхийлсэн юм. Зарим нь сонгуулийн санал худалдаж авах ажиллагаа ялангуяа ядуу хорооллуудаар явагдаж буй тухай асуудлыг сөхөж байлаа.<sup>29</sup>

*Сонгуулийн сурталчилгаанд төрийн захиргааны нөөц, төрийн албан хаагчдыг зүй бусаар ашиглахыг хориглох болон төрийн албан хаагчийн чиг үүрэг, тэдний сонгуулийн сурталчилгаанд оролцох ургийн ялгааг хуульд тодорхой заасан байх ёстой. Эрх бүхий албан тушаалтнууд төрийн байгууллагын эд хөрөнгө, нөөцийг ашиглах, түүнтэй холбоотой бусад зөрчлөөс урьдчилан сэргийлэх, шийдвэрлэх талаар идэвхтэй ажиллах ёстой.*

Сонгууль болохоос хэдхэн сарын өмнө Засгийн газар нийгмийн өөр өөр бүлгийн хүмүүст татаас болон бусад тэтгэмж олгох томоохон хөтөлбөрүүд хэрэгжүүлсэн. Хэдийгээр эдгээр хөтөлбөрүүдийг КОВИД-19 цар тахлын нийгэм, эдийн засагт үзүүлсэн нөлөөг саармагжуулах зорилгоор хууль ёсны дагуу хэрэгжүүлсэн гэж олонд мэдээлсэн ч эдгээр алхмууд нь сонгуулийн өмнөх хэдэн саруудад эрх баригч намын нэр хүндийг илт нэмэгдүүлсэн.<sup>30</sup>

Энэ удаагийн сонгуульд үндэсний цөөнхийн хэл дээрх сонгуультай холбоотой мэдээлэл хязгаарлагдмал байв.<sup>31</sup> Нэр дэвшигчид сонгуультай холбоотой зарим материалыа казак хэлээр хэвлүүлж, мөн СЕХ зарим тараах материал, нийгмийн сүлжээний контент зэрэг сонгогчийн боловсролтой холбоотой агуулгуудаа казак хэлээр гаргасан. Хуулинд хэвлэл мэдээллийн байгууллагууд хөтөлбөрөө үндэсний цөөнхийн хэлээр гаргах шаардлага байхгүй бөгөөд

<sup>28</sup> 6-р сарын 8-ны өдөр, “Бодлогод залуусын хяналт” ТББ цагдаагийн байгууллагад дараах гомдлыг гаргасан байна. Уг гомдолд Монгол Улсын Хууль сахиулах их сургуулийн эзэмшлийн автомашин МАН-ын сонгуулийн сурталчилгаанд явж байгааг дурдан, зурган нотлох баримтаар хангасан байна. “Сонгуулийн үйл явцын үед захиргааны нөөцийг зүй бусаар ашиглахаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах тухай 2016 оны АИХЭГ болон Венецийн комиссын хамтарсан удирдамжийн Б.1.1-д “Сонгуулийн сурталчилгааны зорилгоор олон нийтийг хамарсан албан ёсны арга хэмжээ, тэр дундаа буяны арга хэмжээ, аль нэг улс төрийн нам, нэр дэвшигчийг дэмжсэн, үгүйсгэсэн арга хэмжээ зохион байгуулах замаар төрийн эрх баригчид албан тушаалаа шударга бусаар хэтрүүлэн ашиглахыг хориглох үр дүнтэй механизмыг хууль эрх зүйн орчин бүрдүүлэх ёстой”. Бүр тодруулбал, тодорхой санхүүжилт (улсын болон орон нутгийн төсөв) хэрэглэн зохион байгуулсан арга хэмжээ, төрийн байгууллагын нөөц, эд хөрөнгө (ажилчид, автомашин, дэд бүтэц, утас, компьютер гэх мэт) зэрэг зүйлийг ашиглаж болохгүй гэжээ.

<sup>29</sup> 6-р сарын 14-ний өдөр сонгуультай холбоотой 7 эрүүгийн хэрэг хянагдаж байгаа талаар Ерөнхий прокурор мэдэгдсэн, үүний 5 нь сонгогчдод бэлэн мөнгө тараасантай холбоотой байна.

<sup>30</sup> 2020 оны 4-р сарын 13-ны өдөр УИХ ажилгүйдлийн тэтгэмж, хүүхдийн мөнгө, тэтгэврийн зээл тэглэх, импортын зарим барааг татвараас чөлөөлөх болон бусад нийгмийн халамжийн чиглэлийн үйл ажиллагаа зэргээр цар тахлын эсрэг хэд хэдэн арга хэмжээг баталсан. Засгийн газар 2020 оны 12-р сараас 2021 оны 7-р сар хүртэл сайжруулсан түлшний хөнгөлөлтийг нэмэгдүүлж, айл өрхийн цахилгаан, дулаан, ус, хогны төлбөрийг чөлеөлжээ.

<sup>31</sup> 2020 оны тооллогын дагуу нийт иргэдийн 3.8 хувь нь Казак, Баян-Өлгий болон Улаанбаатар хонтоо суурьшдаг байна. Бусад үндэсний цөөнхөд Дөрвөд (2.6 хувь), Баяд (2 хувь), Буриад (1.4 хувь), Захчин (1.2 хувь) болон Дарьганга (1.1 хувь) байдаг байна.

МОҮОНРТ зэрэг өргөн нэвтрүүлгийн сувгууд, сонгуулттай холбоотой контентоо зөвхөн монгол хэлээр дамжуулсан байна.

## X. СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГААНЫ САНХҮҮЖИЛТ

Сонгуулийн сурталчилгааны санхүүжилтийн тайлан илгээх үйл явц тодорхой хэмжээнд сайжирсан боловч сурталчилгааны санхүүжилтийн ерөнхий тогтолцоонд хяналт, ил тод байдлын хангалттай зохицуулалт байхгүй. Нэр дэвшигчид сурталчилгаагаа өөрийн санхүүжүүлтээр, нэр дэвшүүлсэн намын хөрөнгөөр болон намын тусгайлан нээсэн сонгуулийн нэрийн дансаар дамжуулан хувь хүн (3 хүртэл сая төгрөг) болон хуулийн этгээдийн (15 хүртэл сая төгрөг) хандиваар санхүүжүүлж болно.<sup>32</sup> Хандивлагч нь намын сонгуулийн зардлын дансанд жилд нэг удаа хандив өгч болох ба хугацаа хэтэрсэн эсвэл албан татварын өр, төлбөргүй байх ёстой. Сонгуулийн сурталчилгааны санхүүжилтийг банкны зээл, насанд хүрээгүй хүн, үйлдвэрчний эвлэл, шашны байгууллага, гадаад улс буюу гадаадын хөрөнгө оруулалтын эх үүсвэртэй байгууллага, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдээс хандив авч санхүүжүүлэхийг хориглосон байна. Гэсэн хэдий ч төрийн байгууллагатай гэрээтэй ажилладаг хувийн хуулийн этгээд хандив өгөх эрх нь нээлттэй юм. Нэр дэвшигчдэд өгөх мөнгөн бус хандивыг зах зээлийн дундаж ханшиг үндэслэн хандивын гэрээ байгуулсны үндсэн дээр өгөхийг хүлээн зөвшөөрсөн байна.

Сонгуулийн сурталчилгаатай холбоотой бүх мөнгөн гүйлгээ тусгайлан нээсэн сонгуулийн зардлын дансаар хийгдэнэ. Сонгуулийн зардлын дансанд хуримтлагдах мөнгөн дүнгийн дээд хэмжээг заагаагүй боловч ЯАГ-аас энэ сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээг нэг нэр дэвшигчид ойролцоогоор 8.1 тэрбум төгрөг байхаар тогтоосон ч сонгуулийн зардлын дээд хэмжээг хэтрүүлсэн тохиолдолд ямар ч хуулийн хариуцлага хүлээхгүй<sup>33</sup>. Сонгууль дууссаны дараа сонгуулийн зардлын дансыг битүүмжлэх буюу зарлага гаргахыг хориглосон бөгөөд данс үлдэгдэлтэй бол дараагийн сонгуулиар хэрэглэх боломжтой. Энэ зохицуулалт болон зөвшөөрөгдсөн зардлын дээд хэмжээ өндөр байх нь олон жил болсон улс төрийн намуудад давууталыг бий болгож болзошгүй юм.

ECTХ-нд зааснаар ЯАГ нь сонгуулийн сурталчилгааны санхүүжилтэд хяналт тавих үүрэгтэй үндсэн байгууллага боловч сонгуулийн сурталчилгааны үеэр газар дээр нь эдгээр хяналтыг хэрэгжүүлдэггүй. Түүнчлэн ЯАГ нь сонгуулийн санхүүжилтийн бүх зардал, бэлэн бус хандивын талаарх мэдээллийг улс төрийн намууд санхүүгийн тайландаа оруулсан эсэхийг баталгаажуулах боломжгүй байдаг.

*Үндэсний аудитын газрыг нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын талаар газар дээр нь мэдээлэл цуглуулах зэрэг сонгуулийн санхүүжилттэй холбоотой хяналт, мониторингийг хэрэгжүүлэх хангалттай нөөц, бололцоогоор хангах нь зүйтэй.*

АИХЭГ-ЫН өмнө нь өгсөн зөвлөмжүүдийг үл харгалзан, намууд сурталчилгааны ажлын орлого, зарлагын сонгуулийн өмнөх тайланг илгээх, нийтлэх үүрэг хүлээхгүй байгаа нь сонгуулийн өдрийг хүртэлх сурталчилгааны ажлын санхүүжилтийн ил тод байдлыг хязгаарлаж байна.<sup>34</sup> ЯАГ-аас намуудад санхүүгийн тайлангаа илгээх онлайн платформ, тайлангийн загварыг

<sup>32</sup> Нэг евро ойролцоогоор 3,150 төгрөгтэй тэнцэнэ.

<sup>33</sup> Ойролцоогоор 2.5 сая евро юм.

<sup>34</sup> НҮБ-ын Авлигын эсрэг 2003 оны конвенцийн 7.3-т “Оролцогч улс орнууд нь төрийн албанд нэр дэвшигчдийн санхүүжилт, шаардлагатай тохиолдолд улс төрийн намуудын санхүүжилтийн ил тод байдлыг дээшлүүлэх чиглэлээр хууль тогтоомжийн болон захиргааны зохих арга хэмжээг авах талаар авч үзнэ” гэж заасан.

танилцуулсан нь сайшаалтай байлаа. Тайлланг эхлээд тухайн намын сонгосон хувийн аудитын байгууллагаар хянуулах ёстай бөгөөд сонгууль болсноос хойш 45 хоногийн дотор ирүүлэх ёстай. Хуулинд сонгуулийн зардлын тайллангаа хуульд заасан хугацаанд ирүүлээгүй намыг дараагийн сонгуульд бүртгэхгүй байхаар заасан байна.

ҮАГ нь аудит хийгдсэн эцсийн тайланг хянаж, үнэлгээнийхээ үр дүнг 60 хоногийн дотор нийтэд мэдээлэх бөгөөд нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд мэдээлнэ. Гэсэн хэдий ч, тус хуулиар ҮАГ-т намуудын сонгуулийн сурталчилгааны санхүүгийн тайланг өөрийн цахим хуудаснаа нийтлэх үүрэг, хяналтын дүгнэлтээ хэрхэн нийтлэх, үнэлгээг ямар хэмжээнд нарийвчлан гаргах тухай тодорхой зохицуулаагүй нь ил тод байдлыг хангалттай баталгаажуулж чадахгүйд хүргэж байна.

*Ил тод байдал, хариуцлагын механизмыг сайжруулахын тулд нэр дэвшигчдийн сурталчилгааны санхүүгийн тайлан болон Үндэсний аудитын газрын үнэлгээг цахимаар нээлттэй байшиуулж олон нийтийг хянах, танилцах боломжсоор хангах нь зүйтэй. Түүнчлэн, санхүүгийн явцын тайлан зэрэг санал авах өдрөөс өмнөх нэр дэвшигчдийн орлогыг нийтэд мэдээлэх шаардлагыг хуульчилах нь зүйтэй бөгөөд энэ нь сонгогчидын мэдээлэл суурилж сонголт хийх боломжийг нэмэгдүүлнэ.*

ҮАГ нь сонгуулийн сурталчилгааны санхүүжилттай холбоотой хуулийн зохицуулалтад нийцэхгүй байгаа аливаа зөрчилд хариуцлага тооцох эрхгүй тул зөрчлүүдийн талаарх мэдээллийг Татварын улсын байцаагч (хандив өгөх шаардлага хангасан эсэх), Сангийн яам (тайлагнах), Төв банк (зардлын данс) зэрэг шалган шийдвэрлэх эрх бүхий төрийн захиргааны байгууллагад шилжүүлдэг. Ихэнх зөрчлийг шүүхээр хянан шийдвэрлэхээр хуульчилсан бөгөөд бусад холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээлгэдэг.<sup>35</sup>

*Сонгуулийн сурталчилгааны санхүүжилтийн зөрчилд хүлээлгэх үр дүнтэй, хангалттай, тохирсон хариуцлагын бүрэн хэрэгжихүйц, хялбаршуулсан хуулийн зохицуулалтыг нэвтрүүлэх нь зүйтэй.*

## XI. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ

### A. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ОРЧИН

Хэвлэл мэдээллийн орчин маш идэвхтэй боловч сурталчилгааны хязгаарлагдмал зах зээлд 500 орчим хэвлэл мэдээллийн байгууллага үйл ажиллагаа явуулж байгаагаас ихэнх нь санхүүгийн хувьд бие даасан бус байдаг.<sup>36</sup> Тиймээс ихэнх хэвлэл мэдээллийн байгууллагууд улс төрийн сонирхол бүхий эзэмшигчээсээ хамааралтай байдаг ба редакцын мэдээ, мэдээллээ арилжаалах хандлагатай байдаг тухай АИХЭГ-ЫН САТХ-той уулзаж ярилцсан хүмүүс дурджээ. Интернэтийн өргөн хүртээмжийн ачаар олон нийтийн сүлжээ, ялангуяа Фэйсбууκ нь телевизтэй дүйцэхүйц улс төрийн мэдээлэл авах үндсэн эх сурвалж болж байна. Томоохон өргөн нэвтрүүлгийн сувгууд болон цахим мэдээллийн сайтууд Фэйсбууκ ашиглан өөрийн мэдээлэл, контентийг түгээн дэлгэрүүлдэг.

<sup>35</sup> Сурталчилгааны санхүүжилтийн татвартай холбоотой зөрчлийг Татварын ерөнхий хуулиар зохицуулна. Бусад төрлийн зөрчлийн хувьд Зөрчлийн тухай болон Төрийн албаны тухай хуулиар тус тус зохицуулагддаг. Зөрчил нь эрүүгийн шинжтэй бол Эрүүгийн хуулиар хариуцлага хүлээнэ.

<sup>36</sup> [2020 оны Монгол Улсын хэвлэлийн хүрээлэнгийн Хэвлэл мэдээлэл өнөөдөр](#) сэтгүүлийн дагуу Монгол Улсад 502 хэвлэл мэдээллийн байгууллага байна, үүнээс 140 нь телевиз, 51 радио, 157 хэвлэмэл мэдээллийн байгууллага ба 154 нь мэдээний цахим хуудас байна.

Монголын олон нийтийн радио, телевиз болох *Монголын үндэсний олон нийтийн радио, телевиз (MYONRT)* нь нэвтрүүлгээ улс даяар цацдаг цорын ганц өргөн нэвтрүүлгийн суваг юм. MYONRT нь телевизийн 5 суваг, радио 3 сувагтай бөгөөд Олон нийтийн радио, телевизийн тухай хуулиар редакцийн бие даасан, хараат бус байдлыг нь зохицуулдаг байна. MYONRT нь 15 гишүүн бүхий Үндэсний зөвлөлтэй бөгөөд 7 гишүүнийг нь Улсын Их Хурал, 4 гишүүнийг нь Ерөнхийлөгч, 4 гишүүнийг нь Засгийн газар 6 жилийн хугацаатайгаар тус тус томилдог. MYONRT-ын санхүүжилтийн ихээхэн хэсэг нь улсын төсвөөс санхүүждаг ба төсвийг нь жил бүр Засгийн газар болон эрх баригч нам шийдвэрлэн, батладаг нь олон нийтийн хэвлэл мэдээллийн эрх зүйн болонсанхүүжилтийн бие даасан байдлын талаарх олон улсын хэм хэмжээг зөрчиж байна.<sup>37</sup>

*Улс төрийн аливаа нөлөөллөөс олон нийтийн өргөн нэвтрүүлгийн сувгийг ангиid байлгаж, түүний бие даасан байдлыг сайжруулах, ялангуяа санхүүжилтийн тогтолцоог нь шинэчилэхэд анхаарах хэрэгтэй.*

## B. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Үндсэн хуулиар хэвлэл мэдээллийн болон үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг хангадаг. Ерөнхийдөө, хууль тогтоомжоор хэвлэл мэдээллийн зохистой эрх зүйн орчинг бурдүүлсэн бөгөөд сүүлд 2019 онд батлагдсан Өргөн нэвтрүүлгийн тухай хууль нь хэвлэл мэдээллийн байгууллагын эзэд хэн болохыг ил болгож, эрх мэдлийн төвлөрлийг саармагжуулах зохицуултаараа эрх зүйн орчинг улам сайжруулсан байна.<sup>38</sup> 1998 онд батлагдсан Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулиар төрөөс тавих цензурыг хориглосон бөгөөд 2017 онд гутаан доромжлохыг гэмт хэрэгт тооцоого барьсон байна. Гэсэн хэдий ч хүнд шийтгэл бүхий “худал мэдээлэл”, гүтгэлэгтэй холбоотой зүйл заалтууд зарим хуульд хадгалагдаж, хэд хэдэн хуульд шинээр нэмэгдсэн.<sup>39</sup> Эдгээр заалтууд нь сэтгүүлчид өөрсдөө цензур тавихад хүргэдэг талаар АИХЭГ-ын САТХ-той уулзсан зарим хүмүүс тэмдэглэсэн байна.

*Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг зүй бусаар хязгаарлаж болзошгүй гутгэлэгтэй холбоотой зохисгүй шийтгэлийг эргэн харах хэрэгтэй. Худал мэдээллийг тараахтай холбоотой хуулийн заалтыг хүчингүй болгоход анхаарах нь зүйтэй.*

Харилцаа холбооны зохицуулах хороо (ХХЗХ) нь өргөн нэвтрүүлгийн болон цахим мэдээллийн хэрэгслийг зохицуулах чиг үүрэг бүхий үндсэн байгууллага юм. ХХЗХ нь өргөн нэвтрүүлгийн тусгай зөвшөөрөл олгох, хэвлэл мэдээллийн байгууллагын үйл ажиллагаа нь хуульд нийцэж буй эсэхийг хянан шалгах, холбогдох дүрэм, журам боловсруулах, өргөн нэвтрүүлгийн болон цахим мэдээллийн хэрэгсэлд хариуцлага тооцдог эрх бүхий байгууллага юм. ХХЗХ нь төрийн захиргааны байгууллага бөгөөд тус байгууллагын дарга болон удирдах зөвлөлийн 6 гишүүнийг

<sup>37</sup> Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн хараат бус байдал, редакцийн эрх чөлөөг баталгаажуулж, тогтвортой санхүүжилтээр хангахыг ИУТЭТОУП-ын 34 тоот Ерөнхий тайлбарын 16-р зүйлд заасан байдаг.

<sup>38</sup> 2001 онд батлагдсан Харилцаа холбооны тухай хууль, 1998 онд батлагдсан Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль, 2005 онд батлагдсан Олон нийтийн радио, телевизийн тухай хууль, 2011 онд батлагдсан Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, 2019 онд батлагдсан Өргөн нэвтрүүлгийн тухай хууль зэрэг хуулиудаар хэвлэл мэдээллийн салбарын харилцааг зохицуулж байна.

<sup>39</sup> 2020 оны 1-р сард баталсан, Эрүүгийн хуулийн 13.14-т, “Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан бол дөрвөн зуун тавин нэгжээс нэг мянга гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дочин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас гурван сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.”. Мөн хуулийн 14.8 болон ЕСТХ-ийн 31.4-өөр сонгуулийн үеийн худал мэдээлэлтэй холбоотой зөрчлийг зохицуулдаг байна. Коронавируст халдварт /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 12.3, 13.3 дэх заалтыг харна уу.

Ерөнхий сайд 6 жилийн хугацаатайгаар томилдог. Энэхүү тогтолцоо нь олон улсын сайн туршлагын эсрэг зохицуулах хороог улс төрийн нөлөөнд автахад хялбар, бие даасан байдлыг хангаж чадахгүйд хүргэж байна.<sup>40</sup>

*Харилцаа холбооны зохицуулах хорооны гишүүдийг Засгийн газар томилдог төрийн захиргааны байгууллагаас нь өөрчлөн бие даасан зохицуулах хороо болгон, удирдах зөвлөлийн гишүүдийг томилдог тогтолцоог шинэчлэх хэрэгтэй.*

Хэвлэл мэдээллийн зөвлөл нь 2015 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд хэвлэмэл, цахим болон өргөн нэвтрүүлгийн мэдээллийг зохицуулдаг өөрийн зохицуулалттай бүхий байгууллага юм. Тус байгууллага нь гишүүдийн ёс зүйн дүрэм боловсруулж, хэвлэл мэдээлэлтэй холбогдох өргөдөл, гомдол хүлээн авч, мэргэжлийн стандартыг сайжруулахаар сэтгүүлчидтэй хамтран ажилладаг ба Монгол Улсад хэвлэлийн эрх чөлөөг хамгаалах зорилгоор хуулийн реформыг дэмждэг.

### C. Сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх эрх зүйн зохицуулалт

Сонгуулийн сурталчилгаанд хамаарах үйл ажиллагаа болон өргөн нэвтрүүлгийн суваг, интернэтээр цацах мэдээллийг ECTX-иар зохицуулсан.<sup>41</sup> Сонгуулийн хуулиар *МООНРТ* нэг өдөрт 15 минутын эфирийн цагийг нэр дэвшигч бүрт төлбөргүйгээр олгох ба арилжааны телевиз нэг өдөрт нэг нэр дэвшигчийн 15 минутаас илүүгүй төлбөрт улс төрийн нэвтрүүлгийг дамжуулж болно.

ECTX-нд сонгуулийн үйл явцын мэдээллийг дамжуулахдаа тэнцвэртэй байх тухай заалт байдаг ч хэт зааварласан, редакцын эрх чөлөөг хязгаарласан шинжтэй заалтууд мөн байдаг байна. Тодруулбал, нэг нэр дэвшигчийн талаарх мэдээний хугацаа хоногт таван минутаас ихгүй байх; сонгуулийн сурталчилгаа албан ёсоор эхлэхээс өмнө нэр дэвшигчидтэй ярилцлага хийх, нэр дэвшигчийн хийгсэн болон нэр дэвшигч оролцсон аливаа нэвтрүүлэг, хөтөлбөр, дуу, дүрс бичлэг, ярилцлагыг радио, телевизээр нэвтрүүлэх, нийтлэхийг хуулиар хориглосноос гадна сонгуулийн мэтгэлцээнийг зохион байгуулж, эфирээр цацахад бүх нэр дэвшигчид оролцсон байх зэрэг заалтуутдтай. Түүнчлэн, ECTX-иар мэдээний хөтөлбөрийн дундуур улс төрийн нам, нэр дэвшигчийн төлбөртэй сурталчилгааны дүрс бичлэгийг цацахыг зөвшөөрсөн нь редакцын бие даасан байдлыг бууруулж байна (*Сонгуулийн сурталчилгааны хэвлэл мэдээлэл хэсгийг харна уу*).

Сонгуулийн сурталчилгааны үеэр цахим орчин ашиглах тухай ECTX-ийн зохицуулалт нь хэт хязгаарласан шинжтэй байна. Тухайлбал, сонгуулийн сурталчилгаа эхлэхээс өмнө томоохон мэдээллийн цахим хуудсууд зэрэг хэд хэдэн цахим хуудас, тэдний нийгмийн сүлжээний хуудсууд XX3X-нд бүртгүүлэх шаардлагатай байв.<sup>42</sup> ECTX нь цахим хуудас ашиглан сонгуультай холбоотой мэдээ нийтлэлсурталчилгаа сэтгэгдэл бичигдэхгүй тохиргоотойгоор нийтэлнэ гэж зааснаас өөр бүртгэлтэй цахим хуудаснуудад чиглэсэн тодорхой зохицуулалтгүй тул эдгээр цахим хуудаснуудыг бүртгүүлэхийг ямар зорилгоор шаардсан нь тодорхойгүй байна. Мэдээний цахим хуудаснаа нийтлэгдсэн ихэнх мэдээлэл нь тэдний нийгмийн сүлжээний

<sup>40</sup> Европын комиссын Сайд нарын зөвлөлийн ([2000 оны](#)) 23-р Зөвлөмж нь олон ургальч үзлийг хүндэтгэж, аливаа улс төрийн бүлэг, нам ноёрхлоос зайлсхийхийн тулд томилгооны шалгуурыг тодорхой тодорхойлохыг шаарддаг.

<sup>41</sup> ECTX-ийн 41, 42 дэх хэсэг.

<sup>42</sup> Энэ удаагийн сонгуулийн хувьд [XX3X](#) 204 цахим хуудас, 257 Фэйсбууц хуудас, 60 Твиттер, 11 инстаграм, 38 YouTube суваг, 10 утасны апликацийн бүртгэсэн байна. ECTX-ийн 42.1, XX3X-ны журмын 3.1 дэх хэсэгт заасны дагуу төлбөртэй улс төрийн контент нийтлэх гэж буй цахим хуудаснууд XX3X-нд бүртгүүлэх ёстой. Гэсэн хэдий ч, CATX-д хэлэхдээ улс төрийн төлбөртэй цахим контентийг хянах ямарч аргачлал, механизм байгаагүй байна.

хуудаснаа давхар тавигдаж байсан ба энэ тохиолдолд сэтгэгдэл бичихийг хориглоогүй нь дээрх зохицуулалт маш үр дүнгүй болохыг баталж байна. ECTX-иар ХХЗХ-нд цахим мэдээллийн хэрэгслийн платформыг сурталчилгааны сүүлийн өдрөөс санал авах өдөр дуусах хүртэл цуцлах эсвэл хүчингүй болгох эрх мэдлийг олгож буй нь олон улсын жишигт нийцэхгүй байна.<sup>43</sup>

*Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулиар редакцын эрх чөлөөнд халдаж буй зүйл заалт, мөн мэдээ болон улс төрийн нам, нэр дэвшигчийн гаргадаг төлбөртэй контентийн зааг ялгааг бүдгэрүүлсэн зүйл заалтыг хүчингүй болгоход анхаарах нь зүйтэй.*

Сонгуулийн үеийн өргөн нэвтрүүлгийн болон цахим мэдээллийн хэрэгсэлд тавих хяналтыг СЕХ, Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар (ШӨХТГ) болон ХХЗХ гэх мэт хэд хэдэн байгууллага хуваан хэрэгжүүлэх бөгөөд ХХЗХ голлох үүрэг хүлээдэг. ХХЗХ нь бүртгэлтэй радио, телевизүүд нэр дэвшигчийн талаарх хоногт гаргах мэдээний хугацаа болон нэр дэвшигчийн төлбөртэй сурталчилгааны контент хуулийн дагуу эсэхэд хяналт тавьж ажилладаг. Харин ECTX-нд заасан мэдээллийн дамжуулахдаа тэнцвэртэй байдлын тухай заалт хэрхэн хэрэгжиж байгаад хяналт тавьдаггүй байна.<sup>44</sup> Хэвлэл мэдээллийн байгууллагын сонгуулийн сурталчилгааны контент, цахим контент болон улс төрийн сурталчилгааг тэнцвэртэй гаргаж буйд хяналт тавих чиг үүргийг ШӨХТГ хүлээдэг ч хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх хүчин чадал хомс бөгөөд зөвхөн нийтийн санал асуулгын үр дүнг нийтлэхийг хориглосон журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байна.<sup>45</sup> ШӨХТГ нь хяналтын чиг үүргээ хүлээн авсан өргөдөл, гомдолд суурилан хэрэгжүүлдэг, харин шийтгэл ногдуулах эрх нь сануулах арга хэмжээгээр хязгаарлагддаг тул, зөвшөөрлийг хүчингүй болгох зөрчлийг цаашид арга хэмжээ авахуулахаар ХХЗХ-руу шилжүүлдэг байна. ECTX-иар ХХЗХ-нд хэвлэл мэдээллийн хэрэгслийн эрхийг шүүхийн шийдвэрлгүйгээр цуцлах зэрэг эрх мэдлийг өргөн хүрээнд олгож буй нь олон улсын жишигт нийцэхгүй байна.<sup>46</sup>

ШӨХТГ-ын зэрэгцээ хэвлэл мэдээлэлтэй холбоотой гомдлыг Цагдаагийн ерөнхий газар (ЦЕГ) болон бусад төрийн байгууллагуудад гаргаж болно.<sup>47</sup> ХХЗХ нь ШӨХТГ болон ЦЕГ-аас хэдэн зуун хэвлэл мэдээлэлтэй холбоотой өргөдөл, гомдол хүлээн авсан ба ихэнх нь Фэйсбууц орчинд үйлдэгдсэн бөгөөд нийтийн санал асуулгын үр дүнг нийтлэхийг хориглосон журам болон худал

<sup>43</sup> [2011 оны НҮБ-ын ИУТЭТОУП-ын Ерөнхий тайлбар 34-ийн 19 дүгээр](#) зүйлийн 43 дахь догол мөрийг харна уу. Мөн 2011 оны НҮБ, ЕАБХАБ, АМУХ, АХЭЧХ нарын [Үзэл болдоо чөлөөтэй илэрхийлэх болон интернетийн эрх чөлөөний хамтарсан тунхаглалыг](#) харна уу. Үүнд "... Нийт хүн ам эсвэл олон нийтийг хэсэгчлэн хамарсан интернетийг бүхлээр нь эсвэл хэсэгчлэн таслах (интернетийг хаах) зэрэг үйлдлийг нийтийн хэв журам, үндэсний аюулгүй байдлын үндэслэлээр хэзээ ч зөвтгэж болохгүй. Энэ заалт нь интернэт эсвэл интернетийн зарим хэсэгт тавьсан удаашралд мөн адил хамаарна." НҮБ, ЕАБХАБ, Америкийн муж улсуудын байгууллага, Африкийн хүний болон ард түмний эрхийн комиссын 2020 оны Дижитал эринд сонгуулийн үеэр үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний талаар хамтарсан тунхаглал үзнэ үү. Захиргааны шийдвэрийг шүүхээр хянах тухай ЕАБХАБ-ын болон Ерөнхий зарчмыг үзнэ үү.

<sup>44</sup> Энэ удаагийн сонгуулийн хувьд [ХХЗХ](#) 110 телевиз, 51 радио төлбөртэй нэвтрүүлэг гаргахаар бүртгүүлсэн байна. ХХЗХ нь өөрийн хэвлэлийн мониторинг хийх үүргээ Максима медиа компанийд гэрээлэн өгсөн байна, энэхүү компани нь ХХЗХ-нд тогтмол тайлан илгээдэг ба зөрчлийг мэдэгддэг байна.

<sup>45</sup> ECTX-ийн 43.8-д ээлжит сонгуулийн жилийн 1-р сарын 1-ний өдрөөс хойш нийтийн санал асуулга явуулахыг хориглодог. Ээлжит сонгуулийн жилийн 1-р сарын 1-ний өдрөөс санал авах өдрийг дуусах хүртэл ШӨХТГ нь Фэйсбууц дэх нийт 470 зөрчлийг илрүүлсэн тухай ХХЗХ САТХ-д мэдээлсэн. Зөрчлийг ХХЗХ-нд мэдэгдсэн ба ХХЗХ нь Фэйсбууц компанийд мэдэгдэж 275 зөрчилд арга хэмжээ тооцсон байна.

<sup>46</sup> НҮБ, ЕАБХАБ, Америкийн муж улсуудын байгууллага, Африкийн хүний болон ард түмний эрхийн комиссын [2020 оны Дижитал эринд сонгуулийн үеэр үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний талаар хамтарсан тунхаглал](#) харна уу. Мөн 1990 оны ЕАБХАБ-ын Копенгагены баримт бичгийн 5.10-ийг харна уу.

<sup>47</sup> Фэйсбууц худал мэдээлэл тараахтай холбоотой 363 тохиолдлын талаарх мэдээллийг цагдаагийн байгууллагад хүргүүлсэн тухай ХХЗХ САТХ-д мэдээлсэн. ХХЗХ нь Фэйсбууц компанийд мэдэгдэж 16 зөрчилд арга хэмжээ тооцсон байна.

мэдээлэл тараахтай холбоотой зөрчлүүд байв. ХХЗХ хэлснээр эдгээр зөрчлүүдийг Фэйсбууук компанид мэдээлж улмаар тал шахам зөрчлүүдийг шийдвэрлэсэн байна. Хулээн авсан өргөдөл, гомдол болон тэдгээрийг хэрхэн шийдвэрлэсэн талаарх мэдээллийг олон нийтэд нээлттэй мэдээлээгүй нь үйл явцын ил тод байдалд эргэлзээ төрүүлж байна. ЕСТХ-иар хэвлэл мэдээлэлтэй холбоотой чиг үүрэг, хариуцлагыг хэд хэдэн байгууллагад хуваан хэрэгжүүлэхээр зохицуулсан нь үр дүн муутай бөгөөд хуулийн ил тод байдалд хор хөнөөлтэй юм.<sup>48</sup>

*Хэвлэл мэдээллийн байгууллагад ногдуулах хариуцлагыг шүүхээр хянуулан, хэвлэл мэдээллийн байгууллагын эрхийг шүүхийн шийдвэрийн дагуу хүчингүй болгох нь зүйтэй. Мөн хэвлэл мэдээллийн байгууллагын хяналт, хэвлэл мэдээлэлтэй холбоотой өргөдөл, гомдлыг хүлээн авч, шийдвэрлэдэг хангалттай нөөц бололцоотой бие даасан, хариуцлагатай, ил тод байгууллагад шилжүүлэх талаар бодолцох нь зүйтэй юм.*

#### D. Сонгуулийн сурталчилгааны хэвлэл мэдээлэл

Хэвлэл мэдээллийн байгууллагууд сонгуулийн үйл явцын техникийн нөхцөлийн талаар сонгогчдыг мэдээллээр хангахад хувь нэмэр оруулсан. Гэсэн хэдий ч, хэвлэл мэдээллийн байгууллагууд нэр дэвшигчдийн төлбөртэй мэдээлэл өгөх гол тавцан болж, сонгуулийн хөтөлбөрүүдийн талаарх бие даасан мэдээллийг сонгогчдод бага өгч байлаа. Иргэний нийгмийн байгууллагуудын уулзсан зарим хүмүүс нэр дэвшигчдийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг задлан шинжилж мэдээлэх, хэлэлцүүлэг зохион байгуулах хөтөлбөрүүд дутагдалтай байсныг мэдээлсэн юм. САТХ-ын уулзсан хэвлэл мэдээллийн салбарын хүмүүс сонгуулийн сурталчилгааны хэт хязгаарлагдмал зохицуулалт нь редакцын мэдээ, мэдээлэл бэлтгэх орон зай үлдээгээгүйн зэрэгцээ ЕСТХ-ийг зөрчсөн тохиолдолд өндөр торгуулттай талаар мэдээлсэн. Иймээс ихэнх хэвлэл мэдээллийн байгууллагууд олон нийтэд бие даасан мэдээлэл өгөх үргээсээ татгалzan, хуулиар хүлээн зөвшөөрөгдсөний дагуу улс төрийн нам, нэр дэвшигчдийн төлбөртэй контентийг мэдээний хөтөлбөрийн дундуур цацах болсон нь мэдээний хөтөлбөр болон улс төрийн сурталчилгааны зааг ялгааг бүдгэрүүлсэн бөгөөд мэдээлэлд суурилж сонголт хийх сонгогчдын боломжийг бууруулсан.<sup>49</sup> Мөн адил, цахим мэдээллийн хэрэгслүүд хуулийн хэт хориглосон зохицуулалтуудын талаар гомдолтой байгаагаа илэрхийлсэн бөгөөд ихэвчлэн нэр дэвшигчдийн сонгуулийн сурталчилгаа болон төлбөртэй мэдээллийг нийтэлсэн байна.

Сонгуулийн сурталчилгааны сүүлийн өдөр MYONPT-ээр дамжуулахаар товлогдон, сонгогчдын дунд ихээхэн хүлээлт үүсгээд байсан нэр дэвшигчдийн хоорондын мэтгэлцээн нь нэр дэвшигч Д.Энхбатын КОВИД-19 цар тахлын халдварт авсантай холбоотой цуцлагдсан бөгөөд мэтгэлцээнийг хэрхэн зохион байгуулах талаар талууд нэгдсэн шийдэлд хүрээгүй. Мэтгэлцээний үед мэдээллийг газар дээр нь нягтлан, шууд дамжуулахаар төлөвлөж байсан иргэний нийгмийн байгууллагууд болон цахим мэдээллийн хэрэгслүүд нэр дэвшигчдийн мэтгэлцээнийг цахимаар зохион байгуулах санал дэвшүүлсэн ч амжилт олоогүй байна. Монгол Улсад ерөнхийлөгчийн сонгуулийн мэтгэлцээн олон жилийн түүхтэй арга хэмжээнд тооцогддог ба сонгуулийн сурталчилгааны мэдээлэл, ялангуяа бага байгаа үед сонгогчдын сонголтыг тодорхойлж өгдөг ач

<sup>48</sup> ODIHR previously recommended unifying the oversight of broadcast media under a single independent and accountable body with sufficient resources. АИХЭГ нь өмнө нь хэвлэл мэдээллийн байгууллагын хяналтыг нөөц бололцоотой бие даасан, хариуцлагатай байгууллагад шилжүүлэн нэгтгэх талаар зөвлөж байсан.

<sup>49</sup> ХХЗХ-ны хэвлэл мэдээллийн байгууллагын журмын 3.7-д заасны дагуу 2021 оны ерөнхийлөгчийн сонгуулийн сурталчилгааг нэвтрүүлэхдээ адилхан мэдээний хөтөлбөрөөс төлбөртэй мэдээ болон редакцын мэдээг ялган зааглахыг шаардах нь редакцын болон улс төрийн нам, нэр дэвшигчдийн гаргадаг төлбөртэй контентийн зааг ялгааг бодитоор бий болгох, түүний баталгаа болж чадахгүй байна.

тустай бөгөөд мэтгэлцээн нь нэр дэвшигчдийг хоорондоо мэтгэлцэж байхыг харах ганц боломж юм.<sup>50</sup>

Хуулийн дагуу олон нийтийн радио телевиз нь сонгуулийн сурталчилгааны үеэр бүх нэр дэвшигчдэд үнэгүй эфирийн хугацаа олгосон. ХХЗХ-ны хяналт шалгалтын дүнд хэвлэл мэдээллийн байгууллагууд нь мэдээний цаг болон төлбөртэй улс төрийн мэдээтэй холбоотой хуулийн зохицуулалтыг сайн дагаж мөрдсөн. Глоб интернэшил төв (ГИТ) ТББ нь түүврийн аргаар сонгосон телевизийн сувгуудад мониторинг хийсэн. Сонгуулийн дараах хэвлэлийн бага хуралдаа тэд хоногт гаргах таван минутын мэдээнд хэд хэдэн хөнгөн зөрчлүүд бүртгэгдсэн талаар мэдээлж, телевизүүдийн гаргасан сонгогчийн боловсролын хөтөлбөрүүдийг сайшаасан ч нэр дэвшигчдийн талаар гаргаж буй ихэнх мэдээлэл төлбөртэй мэдээлэл байсныг тодотгосон. Мөн сонгуулийн мэдээ, хөтөлбөрүүдэд эмэгтэйчүүдийн оролцооны асуудлыг орхигдуулсан талаар мэдээлсэн бол САТХ-той уулзсан барах бүх найруулагч, хэвлэл мэдээллийн ТББ-ын төлөөлөл эмэгтэй байсан.

## XII. ИРГЭНИЙ БОЛОН ОЛОН УЛСЫН АЖИГЛАГЧ

ECTХ нь иргэний, олон улсын ажиглагч болон нэр дэвшигчийн төлөөлөл ажиглалт хийхийг зөвшөөрсөн. ECTХ хуулинд сонгуулийн ажиглагчид бүх шатны сонгуулийн хорооны хуралдаан, үйл ажиллагаатай танилцах, санал хураалтын явцыг видео, аудио бичлэгээр баримтжуулах, СТТ-ийн дүнг хэвлэмэлээр болон саналын хуудасны зургийг авах боломжоор хангаж байв. Гэсэн хэдий ч эл хуулиар намын болон нам бус ажиглагчийн ялгааг тодорхойлоогүй тул бүртгэлийн үйл явц нь түвэгтэй байв. ECTХ-иар иргэний ажиглагч өөрийн ажиглах СХХ-ндоо бүртгүүлэх ёстой. Ажиглагч байгууллагуудын бүртгүүлэх СХХ-ын тоог хязгаарлаагүй тул энэхүү төвлөрсөн бус бүртгэлийн үйл явц нь дотоодын ажиглагчдыг хуваарилах, ажиглалт хийхэд хүндрэл учруулж байлаа.

СЕХ иргэний нийгмийн гурван байгууллагын 150 ажиглагч, олон улсын 83 ажиглагчид итгэмжлэл олгов.<sup>51</sup> Түүнчлэн иргэний 4 ажиглагч, улс төрийн намын 14 ажиглагч гадаад улсад байгаа иргэдээс санал авах ажиллагааг ажиглахаар итгэмжлэл авчээ.<sup>52</sup> Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн сүлжээ ТББ нь сонгогчдын бүртгэл, хэвлэл мэдээллийн мониторинг, сонгуулийн зардал, санал тоолох төхөөрөмж, санал авах өдрийн ажиллагааг хамарсан урт хугацааны ажиглалт хийжээ.<sup>53</sup> Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн сүлжээний гишүүн байгууллагууд сонгуулийн өмнө ба дараа хэвлэлийн бага хурлаар өөрсдийн ололт, тайланг танилцуулсан. Монголын багш-эцэг эхийн холбооноос анх удаа сонгуулийн үйл явцын хүртээмжийг үнэлэх зорилгоор ажиглагчид, түүний дотор олон янзын хөгжлийн бэрхшээлтэй ажиглагчдыг ажиллуулав. Сонгууль дуусмагц СЕХ ажиглагч байгууллагуудын төлөөлөлүүдтэй уулзаж сонгуулийн үйл явцыг хэрхэн сайжруулах талаар тэдний ололт, зөвлөмжүүдийг хэлэлцсэн.

СЕХ-гоор итгэмжлэгдсэн иргэний нийгмийн хоёр ажиглагч байгууллага хэсгийн хороонд бүртгүүлэхэд хүндрэлтэй байсан ба нөхөрсөг бус харьцсан талаар мэдээлсэн. Дээрх хоёр байгууллага бүх шатны сонгуулийн байгууллагад ямар нэг хэлбэрийн саад бэрхшээлтэй

<sup>50</sup> Сонгуулийн сурталчилгааны сүүлийн өдөр, АН болон ЗХЭЭ-ийн нэр дэвшигчид Clubhouse нийгмийн сүлжээний хэлэлцүүлэгт оролцож, бодлогын шинжтэй асуултуудад хариулж өгсөн байна. Энэхүү хэлэлцүүлгийг 8,000 хүн даган сонссон бөгөөд энэ нь платформын нэг хэлэлцүүлэгт оролцуулах хүмүүсийн дээд хязгаар юм.

<sup>51</sup> МИДАС ТББ-ыг сонгуулийн үйл явцыг ажиглахаар итгэмжлэл олгосон байна.

<sup>52</sup> Хугацаа хэтэрсэн шалтгаанаар Зөв хүн электорат эвслээс илгээсэн хүсэлтийг хүлээн аваагүй байна

<sup>53</sup> Сүлжээнд Нээлттэй нийгэм форум, Глоб интернэшил төв, Монголын эрэн сурвалжлах сэтгүүлчдийн төв, МИДАС, Бодлогод залуусын хяналт ТББ нар байдаг

тулгарсан байна. Эдгээр саад бэрхшээлийн шалтгааныг СХХ-ны ажилчид холбогдох дүрэм, журам болон ажиглагчийн эрхийн талаар мэдлэг, мэдээлэлгүй байгаатай холбон тайлбарласан.

*Иргэний ажиглагчийн эрх зүйн орчинг сайжруулах нь зүйтэй. Иргэний ажиглагч нь ажиглах хэсгийн хороо бүртээ очиж бүртгүүлдэг байх хуулийн зохицуулалтыг шинэчилж, сонгуулийн байгууллагын ажилтны сургалтад ажиглагчийн эрх, түүнтэй холбоотой дүрэм, журмыг хангальтай оруулж өгөх хэрэгтэй.*

### XIII. СОНГУУЛИЙН ӨДӨР

АИХЭГ-ЫН САТХ нь санал авах өдрийн үйл ажиллагааг иж бүрэн, системтэйгээр ажиглаагүй болно. Зарим санал авах байранд очиж ажиглалт хийхэд сонгууль маш сайн зохион байгуулалттай өрнөж байсан онгуулийн өмнөх өдөр сурталчилгаа явагдаагүй ерөнхийдөө нам гүм байсан ч АИХЭГ-ЫН САТХ-нд улс төрийн намууд сонгогчдыг зөөж байгаатай холбоотой мэдээлэл ирж байсан нь сонгогчийн мэдээллийн төвийг сахих, санал авах өдрийн өмнөх өдөр сурталчилгаа явуулахгүй байх зэрэг хуулийн шаардлагуудыг үл ойшоосон хэрэг байв.

СЕХ-ны мэдээлснээр санал тоолох төхөөрөмжид жижиг хэмжээний техникийн алдаа гарсныг тухайн үед газар дээр нь засварласан байна. СЕХ-ны сонгуулийн мэдээлэл авах шууд утсанд 670 орчим өргөдөл, хүсэлт ирснээс ихэнх нь санал авах байрны байршилыг асуусан бол бусад нь санал авах байрны зохион байгуулалттай холбоотой албан бус гомдол, санал авах байрны халдвартгүйжүүлэх ажиллагаа удаан талаар, хяналтын камерын байршил нь саналаа нууцаар өгөх боломжийг эрсдэлд оруулж байна, саналын хуудасны нууцлалыг хадгалах зориулалттай хавтсыг хэрэглэхгүй байна гэх зэрэг гомдлууд байв. Мөн СЕХ иргэний ажиглагч байгууллагуудаас 35 гомдол хүлээн авсан нь ажиглагчийн эрхэнд зохисгүй хязгаарлалт тавьж байна, хуулиар хориглоогүй хэдий ч сонгуулийн үйл явцыг баримтжуулахаар техник, тоног төхөөрөмж ашиглуулахгүй хорьсон, мэдээлэл авах эрхийг хязгаарласан, саналын хуудасны дижитал дүрс зэрэг шаардлагатай бичиг баримтаар хангахгүй байна зэрэг гомдлууд байв.

Санал хураалт дуусаж, СТТ-ийн дүнг СЕХ-нд илгээсний дараа бүх хэсгийн хороод хяналтын тооллого хийсэн. ЕСТХ-д санал тоолох төхөөрөмжийн үр дүнг албан ёсных байна гэж заасан ч СТТ болон хяналтын тооллогын хооронд зөрүү гарч болох тохиолдлыг ЕСТХ болон СЕХ-ны журамд тусган, авч үзээгүй байна. Энэ удаагийн сонгуулийн дүнд зөрүү гараагүй хэдий ч хяналтын тооллогын үед тэмдэглэгдсэн саналын хуудсыг харуулаагүй, журмын дагуу дарааллаа дагаж, мөрдөөгүй зэрэг нь СХХ-ы ажилчид энэ шатны үйл явцын талаар нэгдмэл ойлголтгүй байгааг харуулж байна хэмээн иргэний ажиглагчид мэдээлж байлаа.

*Санал тоолох үйл явцын туушитай, ил тод байдлыг хангахын тулд санал тоолох төхөөрөмжсөөр болон гар тооллогын хоорондын ялгаатай байдлыг ялган, салгах тодорхой зохицуулалт бий болгох нь зүйтэй.*

Санал авах өдрийн үйл явдлын талаар СЕХ тогтмол мэдээлж, өөрийн цахим хуудаснаа сонгогчдын ирцийн мэдээллийг цаг тухайд нийтэлж байсан нь СЕХ-ны үйл ажиллагааны ил тод байдлыг илтгэж байсан юм. Сонгуулийн ирц урьдчилсан байдлаар 59.35 хувь гэж мэдэгдэв.

### XIV. СОНГУУЛИЙН ДҮНГ НЭГТГЭЖ, ЗАРЛАХ ҮЙЛ ЯВЦ

Санал хураалт дуусаад удалгүй СЕХ-оос аймаг тус бүрийн урьдчилсан дүнг зарлаж эхэлсэн ч, энэ дүнг санал авах байр бүрээр нь задлан харуулаагүй байна. СЕХ-ны мэдээлснээр санал авах

Өдөр дуусахад буюу 00:00 цаг гэхэд СТТ-өөс дүн мэдээний 95 орчим хувь ирсэн. СЕХ-ны мэдээлэлд үндэслэн аймаг бүрийн сонгуулийн урьдчилсан тоон мэдээг хэвлэл мэдээллийн хэрэгслүүд өргөнөөр дамжуулж байсан боловч СЕХ өөрийн цахим хуудаснаа албан ёсоор нийтлээгүй юм. Энэ нь сонгуулийн дүнг буруугаар гаргах болон дүнг нэгтгэх үйл явцын хариуцлага, ил тод байдлыг бууруулах эрсдэл дагуулдаг байна.

СЕХ нь сонгуулийн дүнг хэсгийн хороодоос цаасаар хүлээн авч, СТТ-өөс ирсэн мэдээлэлтэй тулган баталгаажуулсан. СЕХ 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдөр сонгуулийн дүнг баталгаажуулж Ерөнхийлөгчөөр сонгогдсон тооцсон тухай шийдвэрээ Улсын Их Хуралд өргөн барьсны дараа мөн өдөр Улсын Их Хурал шинээр сонгогодсон Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрсөн хуулийг батласан байна. Тус хууль батлагдсаны дараа СЕХ нэгж хэсгийн хороо тус бүрээр задалсан сонгуулийн дүнг эцсийн байдлаар өөрийн цахим хуудаснаа нийтэлсэн байна. Энэ мэдээнд санал хураалтад оролцсон саналын тоог дурдсан ч бусад дэлгэрэнгүй мэдээлэл болох бүртгэлтэй сонгогчдын тоо, санал авах байр бүрийн ирцийн мэдээ, хүчинтэй ба хүчингүй саналын хуудас зэрэг санал хураалттай холбоотой нэмэлт мэдээллийг оруулаагүй байна. ЕСТХ-ийн дагуу Сонгуулийн ерөнхий хороо нь сонгуулийн дүн болон Ерөнхийлөгчөөр сонгогдсон тооцсон тухай шийдвэрийг санал хураалт дууссан өдрөөс хойш 10 хоногийн дотор өргөн мэдүүлнэ гэж заасан бөгөөд СЕХ-ны шийдвэртэй холбогдуулан Үндсэн хуулийн цэцэд гомдол гаргах хугацаагаар хангасан байна. Хэдийгээр СЕХ болон Улсын Их Хурал хуульд заасан хугацаагаа дагаж мөрдсөн ч Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай хуулинд заасан богино хугацаа нь сонгуулийн дүнд гомдол гаргах боломжид сөргөөр нөлөөлсөн.

*Ил тод байдал болон шүүхээр үнэн зөв шийдвэрлүүлэх эрхийг хангахын тулд Сонгуулийн ерөнхий хороо сонгуулийн урьдчилсан болон эцсийн дэлгэрэнгүй дүнг бүхэлд нь мөн хэсгийн хороо бүрээр задлан, цаг хугацаанд нь нийтлэх ёстай. Үүний зэрэгцээ хуулинд Сонгуулийн ерөнхий хорооны нийтэлсэн сонгуулийн дунд гомдол гаргах хангалттай хугацааг өгөх нь зүйтэй. СЕХ-ы нийтэлсэн дунд санал хураалттай холбоотой бүх мэдээлэл, тэр дундаа бүртгэлтэй сонгогчдын тоо, нэр дэвшигч тус бүрийн авсан санал, тэмдэглээгүй санал, болон хүчинтэй ба хүчингүй саналын хуудасны тоо зэрэг мэдээллийг багтаасан байх ёстай бөгөөд ингэснээр сонгуулийн дунд хараат бус шалгалт хийх боломжтой болно.*

## XV. ӨРГӨДӨЛ ГОМДОЛ

Сонгуультай холбоотой зөрчил, гомдлыг хянан шийдвэрлэх хэд хэдэн суваг байдаг ч ихэнх сонгуультай холбоотой маргаан цаг хугацааны хувьд сонгуулийн хуанлитай нийцдэггүй. АИХЭГ-ын өмнөх тайлан, зөвлөмжүүдэд тусгасны дагуу гомдол гаргах, хэрэг хянан шийдвэрлэх хугацаа нь сонгуулийн цаг хугацаатай нийцдэггүй бөгөөд шүүхээр үнэн зөв шийдвэрлүүлэхэд саад болох магадлалтай. Энэ нь ЕАБХАБ-ын өмнө хүлээсэн үүрэг амлалтууд болон олон улсын бусад хэм хэмжээтэй зөрчилдөж байна.<sup>54</sup> Тухайлбал, нэр дэвшигчийн бүртгэлтэй холбоотой маргааныг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх болон Дээд шүүхээр хуульд заасан хугацаандаа хянан шийдвэрлэж дуусах үед санал авах өдөр аль хэдийнээ өнгөрсөн байх юм.

<sup>54</sup>

1990 оны ЕАБХАБ-ын Копенгагены баримт бичгийн 5.10 дахь зүйлд “үндсэн суурь эрхийг хүндэтгэж,, хууль эрх зүйн шударга байдлыг хангах үүднээс хүн бүр захиргааны гаргасан шийдвэрийн эсрэг үр дүнтэй арга хэрэгслийг авах эрхтэй байна” гэж заажээ. Мөн ИУТЭОУП-ын 2.3-р зүйлд “оролцогч улс бүр... энд хүлээн зөвшөөрөгдсөн эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн аливаа этгээдэд хуулиар хамгаалуулах эрхийг хангах үүрэгтэй.” Хэмээн заасан байдал.

ECTХ-ийн дагуу сонгуулийн хорооны шийдвэрийн эсрэг гомдлыг шаталсан зарчмаар дээд шатны сонгуулийн хороо нь хянан шийдвэрлэнэ.<sup>55</sup> СЕХ-ны шийдвэрийн талаар долоо хоногийн дотор Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах бөгөөд хэргийг 30 хоногийн дотор хянан шийдвэрлэх ба энэ хугацааг хамгийн дээд тал нь 10 хоногоор сунгаж болно. Давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг Дээд шүүхэд тав хоногийн дотор давж заалдах боломжтой бөгөөд Дээд шүүх хугацаа сунгах эрхгүйгээр 21 хоногийн дотор хэргийг хянан шийдвэрлэх ёстой. Харамсалтай нь, дээр дурдсан хугацаа шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ердийн хугацаанаас богино боловч Ерөнхийлөгч тангараг өргөсний дараа ч үргэлжлэх магадлалтай юм.<sup>56</sup> Түүгээр ч зогсохгүй эдгээр заалтууд нь гомдол гаргах эрх бүхий этгээд, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг зохицуулдаггүй байна. Шинэ ЕТСХ нь сонгуультай холбоотой гомдол, маргааныг эрх бүхий этгээд нь тухайн жилдээ багтаан шийдвэрлэнэ гэж заасан нь хуулийн бусад хугацаатай зөрчилдөж байна.<sup>57</sup>

*Сонгуулийн гомдол, маргааныг сонгуулийн хуанлитай уялдуулах, цаг хугацаанд нь, шүүхээр үнэн зөв хянан шийдвэрлүүлэх боломжсоор хангахын тулд өргөдөл, гомдол хянан шийдвэрлэх хугацааг богиносгон, шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хялбарчлах нь зүйтэй. Холбогдох хуулийн заалтуудад гомдол гаргах эрх бүхий этгээд хэн болох, гомдол гаргах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зэргийг тодорхой заасан байх ёстой.*

Нэр дэвшигчдийн бүртгэл дууссаны дараа АН-аас нэр дэвшигч Норовын Алтанхуяг нь Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд нэгдүгээрт, өөрийг нынэр дэвшигчээр бүртгэхээс татгалзсан, хоёрдугаарт, АН-ын нэр дэвшигч С.Эрдэнийг бүртгэсэн СЕХ-ны шийдвэрийн эсрэг гомдол гаргасан. Шүүх дээрх гомдлыг тус тус хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн тул тэрээр нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзсан СЕХ-ны шийдвэрийн эсрэг МУ-ын Дээд шүүхэд давж заалдсан байна. Дээд шүүх 2021 оны 6 дугаар сарын 16-ны өдөр давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээжээ.

ECTХ-нд заасны дагуу сонгуулийн үр дүнтэй холбоотой СЕХ-ны шийдвэрийн эсрэг гомдлыг Үндсэн хуулийн цэцэд гаргана. Харамсалтай нь, уг хуулинд гомдол гаргах эрх бүхий этгээд хэн болох, гомдол, маргааныг хэрхэн, ямар журмын дагуу хянан шийдвэрлэх тухай тодорхой заагаагүй байна. Түүгээр ч зогсохгүй, сонгуулийн үр дүнг хүлээн зөвшөөрсөн тогтоол гарч, УИХ Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрсөн тухай хууль баталсны дараа СЕХ-ны шийдвэрийг эсэргүүцэн гомдол гаргаж болох эсэх нь тодорхой бус байна.<sup>58</sup>

*Сонгуулийн дүнд гомдол гаргах иж бүрэн, цогц тогтолцоог бий болгох, түүнд холбогдох цаг хугацаа, журам, гомдол гаргах эрх бүхий этгээд, гомдлыг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зэргийг тодорхой зааж өгч хэрэгжүүлэх нь зүйтэй.*

<sup>55</sup> СЕХ-ны мэдээлснээр сонгуулийн өдөр 670 орчим өргөдөл, хүсэлт сонгуулийн мэдээлэл авах шууд утсаар ирсэн. Ихэнх нь санал авах байрны байршлыг асуусан бол бусад нь санал авах байрны зохион байгуулалттай холбоотой гомдол байсан бөгөөд СЕХ-ны мэдээлснээр бүгдийг шийдвэрлэсэн байна.

<sup>56</sup> Ерөнхийлөгчийн бүрэн эрх нь Үндсэн хуулийн 32.2 дахь зүйлийн дагуу Ерөнхийлөгч сонгогдсоноосоо хойш гуч хоногийн дотор тангараг өргөснөөр эхэлнэ. Сонгуулиас хоёр өдрийн дараа, Улсын Их Хурлын 2021 оны 6-р сарын 11-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар сонгуулийн дунг баталж, тангараг өргөх өдрийг 6-р сарын 25-ны өдрөөр тогтоосон байна. Богино хугацаанд өрнөдөг угүй явц нь гомдол гаргах үйл явцад нөлөөлдөг тул хэдхэн хоногийн дотор шийдвэрээ гаргадаг хэмээн Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн төлөөлөгч АИХЭГ-ЫН САТХ-д хэлж байсан юм.

<sup>57</sup> ECTХ-ийн дагуу шийдвэрийн эрхийг хянан шийдвэрлэх тухай тодорхой зааж өгч хэрэгжүүлэх нь зүйтэй. ЕCTХ-ийн дагуу СЕХ нь сонгуулийн дүнг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх 10 хоногийн хугацаатай байна. Тиймээс холбогдох маргааныг тухайн жилийн 12-р сар хүртэл хянан шийдвэрлэж болохоор харагдаж байна.

<sup>58</sup> ECTХ-ийн дагуу СЕХ нь сонгуулийн дүнг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх 10 хоногийн хугацаатай байна. Энэ удаад СЕХ сонгуулийн маргааш нь сонгуулийн дүн, сонгогдсонд тооцсон тухай шийдвэрээ гаргаж, тэр өдөрөө Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн байна.

Сонгуулийн холбогдолтой эрүүгийн хэрэг, зөрчлийг Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар шалган шийдвэрлэнэ.<sup>59</sup> ЕСТХ-иар санал худалдаж авах зэрэг жижиг зөрчлийг цагдаагийн байгууллага шалгаж, гэмт хэргийн шинжтэй бол Тагнуулын төв газар (ТТГ)-т шилжүүлнэ. Сонгуулийн өмнөх өдөр цагдаагийн байгууллагад сонгуултай холбоотой нийт 41 гомдол ирснээс 19 гомдлыг шийдвэрлэсэн ба үлдсэн 22 гомдлыг нь хараахан шийдвэрлээгүй байв. Сонгуулийн дараа нийт 80 зөрчил бүртгэгдсэний ихэнх нь санал худалдан авахтай холбоотой гомдол байсан ба үүний 40 шахам зөрчил нь санал авах өдөр үйлдэгдсэн талаар Ерөнхий прокурор мэдээлсэн.<sup>60</sup> Уг тайланг бичих үед сонгогчдод нөлөөлөх зорилгоор худал мэдээлэл, мөнгө тараахтай холбоотой эрүүгийн 7 хэргийг мөрдөн шалгаж байсан, үүнээс 5 хэргийг нь цагдаагийн байгууллага, 2 хэргийг нь тагнуулын байгууллага мөрдөн шалгаж байв.<sup>61</sup>

## XVI. ЗӨВЛӨМЖ

Энэхүү тайланд дурдсан зөвлөмжүүдийг цаашид Монгол Улсад явуулах сонгуулийн үйл ажиллагааг сайжруулах, сонгуулийг ЕАБХАБ-ын болон олон улсын өмнө хүлээсэн үүрэг амлалтууд, ардчилсан сонгуултай холбоотой бусад хэм хэмжээтэй нийцүүлэн зохион байгуулахад гаргах хүчин чармайлтыг дэмжин туслах үүднээс санал болгож байна.<sup>62</sup> Эдгээр зөвлөмжийг ЕАБХАБ/АИХЭГ-аас өмнө нь өгсөн, хараахан тусгаж аваагүй зөвлөмжүүдийн хамт уншиж танилцах нь зүйтэй. АИХЭГ нь Монгол Улсын эрх бүхий байгууллагуудыг цаашид сонгуулийн үйл явцаа сайжруулах, мөн энэ болон өмнөх тайланд тусгагдсан зөвлөмжүүдийг хэрэгжүүлэхэд нь туслахад бэлэн байна.

### A. НЭН ТЭРГҮҮНИЙ ЗӨВЛӨМЖҮҮД

1. Улсын Их Хурал сонгуулийн хууль, тогтоомжийг оролцогч талуудтай дараагийн сонгууль болохоос нилээдгүй хугацааны өмнөөс өргөн хүрээнд, оролцооны аргад тулгуурлан хэлэлцэж, шинэчлэх ёстай бөгөөд үүнд АИХЭГ-ын энэхүү тайлан болон өмнөх тайлангуудад өгсөн зөвлөмжүүдийг тусган хэрэгжүүлэх.
2. Нэр дэвших эрх, тэр дундаа хөгжлийн бэрхшээлтэй байдал, оршин суугаа газар, гарал үүсэлтэй холбоотой хязгаарлалтуудыг олон улсын хэм хэмжээтэй нийцүүлэн эргэн харах нь зүйтэй.
3. Улсын Их Хуралд суудалгүй нам болон хувь хүн бие даан нэрээ дэвшүүлэх эрхийг хангах

<sup>59</sup> Зөрчлийн тухай хуульд зөрчлийн 36 төрөл байдаг ба түүнд санал худалдан авах (санал болгох, хүлээн авах), хууль бус сурталчилгаа, сонгуулийн сурталчилгааны санхүүжилттэй холбоотой зөрчил, санал авах өдөр согтууруулах ундаа зарах гэм мэт байдаг байна. Харин Эрүүгийн хуульд гэмт хэргийн 5 төрлийг зохицуулдаг байна, үүнд санал өгөх эрхэд халдах, нэгээс илүү санал өгөх, сонгуулийн дүнд нөлөөлөх, нэр дэвшигчийн нэр хүндийг гутаан доромжлох болон сонгуулийн дүнд урьдчилан төлевлөсөн, зохион байгуулалттайгаар нөлөөлөх.

<sup>60</sup> Худал мэдээлэл тараах, нэр дэвшигчийн нэр хүндэд халдах, хууль бус сурталчилгаатай холбоотой 8 хэрэг бүртгэгдсэн. Бусад нь сонгуулийн өдөр согтууруулах ундаа зарсан, сонгуулийн урьдчилсан дүнг худал мэдээлсэн, бусдын нэр, имэйл хаяг зэргийг ашигласан зөрчлүүд байна.

<sup>61</sup> [Прокурорын ерөнхий газрын харилцаа холбоо](#), сүүлд 2021 оны 6-р сарын 15-нд нэвтрэсэн.

<sup>62</sup> [1999 оны ЕАБХАБ-ын Истанбулын баримт бичгийн](#) 25-р догол мөр, ЕАБХАБ-ын гишүүн улсууд “АИХЭГ-ын сонгуулийн үнэлгээ болон зөвлөмжийг дагаж, мөрдөнө” гэж амласан байна. Өмнөх зөвлөмжүүдийг хэрэгжүүлсэн байдлыг САТХ дүгнэхдээ: 2016 оны Улсын Их Хурлын сонгуулийн эцсийн тайлангийн 13, 27 дахь зөвлөмжүүд бүрэн хэрэгжсэн байна, 1, 3, 5, 15, 20, 26, 28 дахь зөвлөмжүүд хагас дутуу хэрэгжсэн байна. 2017 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн эцсийн тайлангийн ямар ч зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна, харин 1, 22, 22 дахь зөвлөмжүүд бараг бүрэн хэрэгжсэн бол 3, 12, 14, 19, 20, 27, 28 дахь зөвлөмжүүд хагас дутуу хэрэгжсэн байна. Мөн [АИХЭГ-ЫН Сонгуулийн зөвлөмжийн мэдээллийн санг](#) харна уу.

зорилгоор хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах нь зүйтэй.

4. Сонгуулийн сурталчилгаа явуулахад зөвшөөрөгдсөн үйл ажиллагааны төрөл, хэрэглэж болох хөрөнгө, нөөцийг [нэрлэлгүй] хязгаарласан зохицуулалтыг багасгаж хуулийг өөрчлөн батлах ёстой. Мөн сонгуулийн нэг ба хоёр дахь шатны хооронд сурталчилгаа явуулахыг зөвшөөрөх нь зүйтэй.
5. Ил тод байдал болон хариуцлагын механизмыг сайжруулахын тулд нэр дэвшигчдийн санхүүгийн сурталчилгааны тайлан болон Үндэсний аудитын газрын үнэлгээг цахимаар нээлттэй байршуулж олон нийтийг танилцах боломжоор хангах нь зүйтэй. Түүнчлэн, санхүүгийн явцын тайлан зэрэг санал авах өдрөөс өмнөх нэр дэвшигчдийн орлогыг нийтэд мэдээлэх шаардлагыг хуульчилах нь зүйтэй бөгөөд энэ нь сонгогчдод мэдээлэлд суурилж сонголт хийх боломж өгнө.
6. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг зүй бусаар хязгаарлаж болох гүтгэлэгтэй холбоотой зохисгүй шийтгэлийг дахин авч үзэх ёстой. Худал мэдээллийг тараахтай холбоотой хуулийн заалтыг хүчингүй болгоход анхаарах нь зүйтэй.
7. Сонгуулийн гомдол, маргааныг сонгуулийн хуанлитай уялдуулах, цаг хугацаанд нь, шүүхээр үнэн зөв хянан шийдвэрлүүлэх боломжоор хангахын тулд өргөдөл, гомдол хянан шийдвэрлэх хугацааг богиносгон, шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хялбарчлах нь зүйтэй. Холбогдох хуулийн заалтуудад гомдол гаргах эрх бүхий этгээдийн эрх зүйн зохицуулалт, гомдол гаргах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зэргийг тодорхой заасан байх ёстой.

## B. БУСАД ЗӨВЛӨМЖҮҮД

### Хууль, эрх зүйн орчин ба сонгуулийн тогтолцоо

8. Саналын нууцлал, саналын тэгш байдлыг алдагдуулж, сонгогчдыг төөрөгдүүлж болзошгүй эрсдлийг засахын тулд Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн нэмэлт санал хураалт явуулахтай холбоотой заалтыг эргэн харах.

### Сонгуулийн байгууллага

9. Олон нийтэд хамаарал бүхий мэдээллийн ил тод байдал, хүртээмжийг хангахын тулд бүх шатны сонгуулийн байгууллагууд уулзалт, хуралдаанаа нээлттэй, ил тод зохион байгуулж, олон нийтэд урьдчилан зарлан мэдэгдэж, , хуралдааны шийдвэр, хуваарь болон тэмдэглэлийг цаг хугацаанд нь, тогтмол нийтэлж байх нь зүйтэй.
10. Сонгуулийн төхөөрөмжид итгэх итгэлийг нэмэгдүүлэхийн тулд бие даасан, гуравдагч этгээдээр санал тоолох төхөөрөмжийг баталгаажуулах зохицуулалтыг хуульд тодорхой заах ёстой. Сонгуулийн байгууллага нь санал тоолох төхөөрөмжид хийж буй бүх шинэчлэл, туршилтийг баримтжуулж, холбогдох бүх мэдээлэл, тэр дундаа баримтжуулах үйл явц, өөрчлөх хүсэлтүүд болон өөрчилсөн үйлдлүүдийг олон нийтэд мэдээлэх ёстой.

### Сонгогчийн бүртгэл

11. Хууль эрх зүйн орчноо Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн зорилго, зорилтой бүрэн нийцүүлэн, оюуны болон сэтгэцийн бэрхшээлтэй холбоотой иргэдийн санал өгөх эрхийг хязгаарласан бүх заалтыг хүчингүй болгох хэрэгтэй.

12. Хорих ял эдэлж буй бүх хүмүүсийн үйлдсэн гэмт хэргийн ангиллаас үл хамааран санал өгөх эрхийг нь хязгаарласан заалтуудыг олон улсын өмнө хүлээсэн үүрэгт нийцүүлэн дахин авч хэлэлцэх.
13. Сонгогчийн түр шилжилт хийх үйл явцыг хялбаршуулж, санал авах байрнаасаа хол байгаа иргэдийн санал өгөх эрхийг хангах ёстай.
14. Хувь хүний мэдээллийн нууцыг хүндэтгэхийн зэрэгцээ сонгогчийн бүртгэлийн явцад итгэх итгэлийг нэмэгдүүлэх үүднээс улс төрийн нам, иргэний ажиглагчдыг сонгогчдын нэрийн жагсаалтад хангалттай хугацаанд бие даасан шалгалт хийх боломжоор хангах нь зүйтэй.

### **Нэр дэвшигчийн бүртгэл**

15. Төрийн албан хаагчид нэр дэвшигч тодруулах ажиллагаа эхлэх хүртэл эрхэлсэн ажил, албан тушаалаасаа чөлөөлөгдөх шаардлагагүй байх ёстай.
16. Сонгуулийн ерөнхий хороонд нэр дэвшигчийг бүртгэх хангалттай хугацаа өгөхөөс гадна үүнтэй холбоотой шүүхийн маргаан эцэслэн шийдвэрлэгдэх боломжоор хангах зорилгоор нэр дэвшүүлэх хугацааг уртасган, сонгуулийн хуанлид эрт оруулах зохицуулалтыг хийж өгөх ёстай.
17. Нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөр тодорхой бодлоготой нийцэж буй эсэхэд Үндэсний аудитын газар дүгнэлт гарган баталгаажуулдаг шаардлагыг болиулах хэрэгтэй.

### **Сонгуулийн сурталчилгаа**

18. Сонгуулийн сурталчилгаанд төрийн захиргааны нөөц ашиглах, төрийн албан хаагчдыг зүй бусаар ажиллуулахыг хориглох болон төрийн албан хаагчийн чиг үүрэг, тэдний сонгуулийн сурталчилгаанд оролцох үүргийн ялгааг хуульд тодорхой заасан байх ёстай. Эрх бүхий албан тушаалтнууд төрийн байгууллагын эд хөрөнгө, нөөцийг ашиглах, түүнтэй холбоотой бусад зөрчлөөс урьчилан сэргийлэх, шийдвэрлэх талаар идэвхтэй ажиллах ёстай.

### **Сонгуулийн санхүүжилт**

19. Үндэсний аудитын газрыг нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын талаар газар дээр нь мэдээлэл цуглуулах зэрэг сонгуулийн санхүүжилттэй холбоотой хяналт, мониторингийг хэрэгжүүлэх хангалттай нөөц, бололцоогоор хангах нь зүйтэй.
20. Сонгуулийн сурталчилгааны санхүүжилтийн зөрчилд хүлээлгэх үр дүнтэй, хангалттай, тохирсон хариуцлагын бүрэн хэрэгжихүйц, хялбаршуулсан хуулийн зохицуулалтыг нэвтрүүлэх нь зүйтэй.

### **Хэвлэл мэдээлэл**

21. Улс төрийн аливаа нөлөөлөөс олон нийтийн өргөн нэвтрүүлгийн сувгийг ангид байлгаж, түүний бие даасан байдлыг сайжруулах, ялангуяа санхүүжилтийн тогтолцоог нь шинэчилэхэд анхаарах хэрэгтэй.
22. Харилцаа холбооны зохицуулах хорооны гишүүдийг Засгийн газар томилдог төрийн захиргааны байгууллагын статусаас нь өөрчлөн бие даасан, хараат бус зохицуулах хороо болгон, удирдах зөвлөлийн гишүүдийг томилдог тогтолцоог шинэчлэх хэрэгтэй

23. Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулиар редакцын эрх чөлөөнд халдаж буй зүйл заалт, мөн мэдээ болон улс төрийн нам, нэр дэвшигчдийн гаргадаг төлбөртэй контентийн зааг ялгааг бүдгэрүүлсэн зүйл заалтыг хүчингүй болгоход анхаарах нь зүйтэй.
24. Хэвлэл мэдээллийн байгууллагын хяналт, хэвлэл мэдээлэлтэй холбоотой өргөдөл, гомдлыг хүлээн авч, шийдвэрлэдэг хангалттай нөөц бололцоотой нэг бие даасан, хариуцлагатай, ил тод байгууллагад шилжүүлэх талаар бодолцох нь зүйтэй юм.
25. Хэвлэл мэдээллийн байгууллагад ногдуулах хариуцлагыг шүүхээр хянуулан, хэвлэл мэдээллийн байгууллагын эрхийг шүүхийн шийдвэрийн дагуу хүчингүй болгох нь зүйтэй. Хэвлэл мэдээллийн байгууллагын хяналт, хэвлэл мэдээлэлтэй холбоотой өргөдөл, гомдлыг хүлээн авч, шийдвэрлэдэг хангалттай нөөц бололцоотой нэг бие даасан, хариуцлагатай, ил тод байгууллагад шилжүүлэх талаар бодолцох нь зүйтэй юм.

### Иргэний болон олон улсын ажиглагч

26. Иргэний ажиглагчийн эрх зүйн орчинг сайжруулах нь зүйтэй. Иргэний ажиглагч нь ажиглах хэсгийн хороо бүрт очиж бүртгүүлдэг байх хуулийн зохицуулалтыг шинэчилж, сонгуулийн байгууллагын ажилтны сургалтад ажиглагчийн эрх, түүнтэй холбоотой дүрэм, журмыг хангалттай оруулж өгөх хэрэгтэй.

### Сонгуулийн өдөр

27. Санал тоолох үйл явцын тууштай, ил тод байдлыг хангахын тулд санал тоолох төхөөрөмжөөр болон гар тооллогын хоорондын ялгаатай байдлыг ялган, салгах тодорхой зохицуулалт бий болгох нь зүйтэй.
28. Ил тод байдал болон шүүхээр үр дүнтэй хамгаалуулах эрхийг хангахын тулд Сонгуулийн ерөнхий хороо нь сонгуулийн урьдчилсан болон эцсийн дэлгэрэнгүй дүнг бүхэлд нь буюу хэсгийн хороо бүрээр задлан, цаг хугацаанд нь нийтлэх ёстой. Нийтлэсэн сонгуулийн дүнд санал хураалттай холбоотой бүх мэдээлэл, тэр дундаа бүртгэлтэй сонгогчдын тоо, нэр дэвшигч тус бурийн авсан санал, тэмдэглээгүй санал, болон хүчинтэй ба хүчингүй саналын хуудасны тоо зэрэг мэдээллийг багтаасан байх ёстой, ингэснээр сонгуулийн дүнд хараат бус бие даасан хяналт, шалгалт хийх боломжтой болно.

### Өргөдөл, гомдол

29. Сонгуулийн дүнд гомдол гаргах иж бүрэн, цогц тогтолцоог бий болгох ба түүнд холбогдох цаг хугацаа, журам, гомдол гаргах эрх бүхий этгээд, гомдлыг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зэргийг тодорхой зааж өгч хэрэгжүүлэх нь зүйтэй.

**ХАВСРАЛТ – СОНГУУЛИЙН ДҮН<sup>63</sup>**

Бүртгэлтэй сонгогчдын тоо: 2,049,379

Хүчинтэй саналын тоо: 1,215,063

Ирц: 59.35 хувь

**Дүн**

Дангаасүрэнгийн Энхбат: 246,968 (20.31 хувь)

Содномзундуйн Эрдэнэ: 72,832 (5.99 хувь)

Ухнаагийн Хүрэлсүх: 823,326 (67.69 хувь)

Тэмдэглээгүй санал: 71,937 (5.91 хувь)

<sup>63</sup> Эх сурвалж: Сонгуулийн ерөнхий хороо.

## АИХЭГ-ЫН ТУХАЙ

Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага (ЕАБХАБ)-ын үндсэн институт болох Ардчилсан институт, хүний эрхийн газар (АИХЭГ) нь тус байгууллагын оролцогч орнуудад “хүний эрх, үндсэн эрх чөлөөг бүрэн хүндэтгэсэн байдлыг хангах, хууль дээдлэх ёсыг сахих, ардчиллын зарчмыг болон (...) хөхүүлэн дэмжих, ардчилсан институциудыг байгуулах, бэхжүүлэх, хамгаалах, түүнчлэн нийгмийг бүхэлдээ харилцан хүндэтгэлтэй хандах хандлагыг хөхүүлэн дэмжих”-д туслалцаа үзүүлэх зорилготой (1992 оны Хельсинкийн Дээд хэмжээний уулзалтын баримт бичиг). Үнийг ЕАБХАБ-ын хүний хэмжигдэхүүн гэж үздэг байна.

Польш Улсын Варшав хотод байрладаг АИХЭГ нь 1990 оны Парисын Дээд хэмжээний уулзалтын үеэр Чөлөөт сонгуулийн төлөө газар нэртэйгээр үүсгэн байгуулагдсан бөгөөд 1991 оны 5-р сараас үйл ажиллагаагаа эхэлжээ. Тус байгууллагын эрх нь хүний эрх, ардчилалтай холбоотой асуудлаар өргөжсөн тул жилийн дараа уг байгууллагын нэрийг өөрчилсөн. Өнөөдөр тус байгууллага нь 150 гаруй ажилтантай үйл ажиллагаагаа явуулж байна.

АИХЭГ нь сонгуулийн ажиглалт явуулах чиглэлээр Европод тэргүүлдэг байгуулага юм. ЕАБХАБ-ын бүс нутагт явагдаж байгаа сонгуулиуд нь ЕАБХАБ-ын үүрэг амлалт, ардчилсан сонгуулийн төлөөх олон улсын бусад хэм хэмжээ болон үндэсний хууль тогтоомжийг даган мөрдөж байгаа эсэхэд үнэлгээ өгөх олон мянган ажиглагчдыг томилж, сонгуулийн ажиглалтыг жил бүр зохион байгуулдаг. Тус байгууллагын өвөрмөц аргачлал нь сонгуулийн үйл явцад бүрэн ажиглалт хийх боломж олгодог. АИХЭГ нь төрөл бүрийн төсөл, хөтөлбөрөөр дамжуулан сонгуулийн хууль эрх зүйн тогтолцоог сайжруулахад нь оролцогч орнуудад туслалцаа дэмжлэг үзүүлдэг.

АИХЭГ нь **ардчиллын үйл явцыг** дэмжих үйл ажиллагаанд хууль дээдлэх ёс, хууль эрх зүйн дэмжлэг, ардчилсан засаглал, шилжилт хөдөлгөөн, шилжин суух эрх чөлөө, жендерийн тэгш байдал багтана. АИХЭГ нь ардчилсан засаглалыг хөгжүүлэхийг эрэлхийлэн, жил бүр зорилтот төсөл хөтөлбөрүүд хэрэгжүүлдэг.

АИХЭГ нь түүнчлэн **хүний эрх, үндсэн эрх чөлөөг хөхиүүлэн дэмжих, хамгаалах үүргээ ЕАБХАБ-ын хүний хэмжигдэхүүний үүрэг амлалтад нийцүүлэн биелүүлэхэд нь оролцогч орнуудад тусалдаг**. Ингэхийн тулд бусад түнш байгууллагуудтай хамтран терроризмтэй тэмцэх явцад хөндөгдөх хүний эрх, хүний наймааны гэмт хэргийн хохирогчдын эрхийн хамгаалалтыг нэмэгдүүлэх чиглэлээр сэдэвчилсэн хэлэлцүүлгүүд зохион байгуулахын сацуу хүний эрхийн боловсрол, сургалт, хүний эрхийн мониторинг хийж, тайлан гаргах болон эмэгтэйчүүдийн эрх, аюулгүй байдлын талаарх чадавхыг бэхжүүлэх, мэдлэг туршлагаа харилцан хуваалцдаг.

АИХЭГ нь бусад **хүндэтгэлтэй хандах, үл ялгаварлан гадуурхах** чиглэлийн хүрээнд бусдыг үзэн ядах гэмт хэрэг, арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзлийн зөрчил, гадаад иргэдийг үзэн ядах үзэл, семитийн эсрэг үзэл болон бусад хэлбэрийн үл хүндэтгэсэн үйлдэлд хариу арга хэмжээ авах чадавхыг бэхжүүлэхэд оролцгч орнууддаа тусалдаг. ЕАБХАБ-ын АИХЭГ-ын бусад хүндэтгэлтэй хандах, үл ялгаварлан гадуурхахтай холбоотой үйл ажиллагаа нь дараах асуудалд чиглэнэ. Үүнд хууль тогтоомж; хууль хэрэгжүүлэх тухай сургалт; үзэн ядалтаас үүдэлтэй гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх арга хэмжээг хянах, тайлагнах, нягтлах; түүнчлэн бусад хүндэтгэлтэй хандах, хүндэтгэх болон хамтын ойлголцлыг хөхиүүлэн дэмжсэн боловсролын арга хэмжээ зэрэг багтана.

Түүнчлэн АИХЭГ нь **Рома, Синтигийн** (Roma and Sinti) асуудлаар баримтлах бодлогод оролцогч гишүүн орнуудад зөвлөгөө өгдөг. Мөн тэднийг нийгэмшүүлэх, чадавхжуулах, сүлжээ үүсгэх асуудлыг хөхиүүлэн дэмжихийн зэрэгцээ бодлого боловсруулах түвшинд тэдний төлөөллийг оруулцуулахыг дэмждэг.

АИХЭГ нь ЕАБХАБ-ын оролцогч гишүүн орнууд, ЕАБХАБ-ын бусад институци болон олон улсын бусад байгууллагуудтай үйл ажиллагаагаа уялдуулж, харилцан хамтран ажиллаж, хэрэгжүүлдэг.

Дэлгэрэнгүй мэдээлэлтэй АИХЭГ-ын ([www.osce.org/odihr](http://www.osce.org/odihr)) цахим хуудаснаас танилцана уу.